

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-25
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	26-85
<hr/>	
1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	26-38
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	38-51
3.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	51-53
4.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	53-63
5.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/	63-76
6.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	76-77
7.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	77-78
8.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах	78-85

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 12-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 85 гишүүн хүрэлцэн ирж, 67.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 28 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Р.Эрдэнэбүрэн;
Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Д.Бум-Очир, С.Ганбаатар, Д.Ганбат,
С.Лүндэг, Э.Одбаяр, Р.Сэддорж, Г.Уянгахишиг;
Тасалсан: Б.Батбаатар, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр,
Д.Пүрэвдаваа.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, О.Цогтгэрэл, Л.Соронзонболд, Ц.Сандаг-Очир, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх

Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны гаргасан, 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлэн авах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 39
Бүгд: 107
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны гаргасан, 1.Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх:

2.Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй, эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих;

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Ж.Батжаргал, Ж.Галбадрах, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 46
Бүгд: 110
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	75
Татгалзсан:	35
Бүгд:	110

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Д.Батлут, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Ж.Батжаргал нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 110 гишүүнээс 80 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	84
-------------	----

Татгалзсан: 26

Бүгд: 110

76.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85

Татгалзсан: 25

Бүгд: 110

77.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85

Татгалзсан: 25

Бүгд: 110

77.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88

Татгалзсан: 22

Бүгд: 110

80.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 84

Татгалзсан: 26

Бүгд: 110

76.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

9.“Засгийн газарт чиглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 88

Татгалзсан: 22

Бүгд: 110

80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

10.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86

Татгалзсан: 24

Бүгд: 110

78.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Соноор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт

Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ц.Сандаг-Очир, О.Алтангэрэл нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Л.Мөнхбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 12 цаг 17 минутаас 12 цаг 20 минутад хуралдааныг удирдав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дуусав.

Уг асуудлыг 12 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт

Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар 10.2, 10.5-д заасны дагуу зүйл, заалт бүрийг уншин, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

“НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	39
Бүгд:	110

64.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн:	76
Татгалзсан:	34
Бүгд:	110

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

“ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0 100.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	106,372.5 101,600.0 4,772.5
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0 510.0
5	Монгол Улсын Ерөнхий аудитор Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	831.3 831.3
6	Төрийн албаны зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	200.0 200.0
7	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,000.0 4,000.0
8	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3 2,388.3
9	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	20,954.3 20,954.3
10	Монгол Улсын Шадар сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	115.9 115.9
11	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	300.0 300.0
12	Гадаад харилцааны сайд Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	16,100.0 13,000.0 3,100.0
13	Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21,278,121.4 12,731,009.6 608,889.9 7,872,540.0 248,209.1 417,000.0 9,362.6
14	Хууль зүй, дотоод хэргийн сайд Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Шүүх шинжилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	81,156.8 45,730.0 2,370.0 300.0 1,052.5

	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	31,704.4
15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ашигт малтмал, газрын тосны газар Үндэсний геологийн алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	412,848.1 407,301.1 120.0 5,427.0
16	Батлан хамгаалахын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	43,187.2 43,187.2
17	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,226.9 2,226.9
18	Боловсролын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,534.8 5,534.8
19	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	304.0 304.0
20	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	69,153.9 1,000.0 3,035.1 65,118.8
21	Зам, тээврийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	110,656.0 80,000.0 300.0 30,356.0
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	49,173.6 49,173.6
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,663.3 8,663.3
24	Эрүүл мэндийн сайд Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	7,945.3 7,945.3

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 29
Бүгд: 110
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “4 дүгээр зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 22,837,920.9 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 30
Бүгд: 110
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “5 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөрийг төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	387,133.9
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	20,600.7
3	Боловсролын сайд	30,000.0
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	62,310.3

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 28
Бүгд: 110
74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсвийг зарцуулна:

6.1.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	37,603.0 36,603.0 1,000.0
2	Монгол Улсын Их Хурлын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	170,302.4 161,742.4 8,560.0
3	Монгол Улсын Ерөнхий сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	626,974.8 367,312.1 259,662.7
4	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Урсгал зардал	5,488.7 5,488.7
5	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Урсгал зардал Хөрөнгийн зардал	31,861.6 27,233.4 4,628.2
6	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	329,796.4 266,811.9 62,984.5
7	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	14,896.9 12,184.9 2,712.0
8	Улсын ерөнхий прокурор Урсгал зардал Хөрөнгийн зардал	157,568.5 127,719.4 29,849.1
9	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Урсгал зардал	22,569.7 22,569.7
10	Монгол Улсын Ерөнхий аудитор Урсгал зардал	54,388.4 53,209.6

	Хөрөнгийн зардал	1,178.8
11	Авлигатай тэмцэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	56,946.0 54,585.1 2,360.9
12	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	21,703.7 21,453.7 250.0
13	Төрийн албаны зөвлөлийн дарга Урсгал зардал	19,420.4 19,420.4
14	Үндэсний статистикийн хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	34,392.7 32,392.7 2,000.0
15	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Урсгал зардал	15,750.3 15,750.3
16	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Урсгал зардал	1,310.2 1,310.2
17	Шүүхийн сахилгын хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	6,171.9 5,871.9 300.0
18	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	276,031.2 117,454.2 158,577.0
19	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	388,505.5 324,292.9 64,212.6
20	Монгол Улсын Шадар сайд Урсгал зардал	8,046.9 8,046.9
21	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	141,257.7 117,027.1 24,230.6
22	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	19,337.0 16,928.9 2,408.1
23	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	13,537.0 5,438.5 8,098.5
24	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Урсгал зардал Хөрөнгийн зардал	20,051.7 4,380.2 15,671.5
25	Гадаад харилцааны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	262,290.7 251,040.3 11,250.4
26	Сангийн сайд Урсгал зардал үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт Хөрөнгийн зардал	4,877,188.4 2,791,510.7 1,297,070.7 126,249.3

	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,959,428.4
27	Хууль зүй, дотоод хэргийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,725,373.2 1,616,821.3 108,551.9
28	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	48,952.1 27,968.1 20,984.0
29	Батлан хамгаалахын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	819,580.7 744,176.8 75,403.9
30	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	308,571.6 227,741.8 80,829.8
31	Боловсролын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,466,080.8 3,993,403.0 472,677.8
32	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	4,495,704.2 4,443,461.9 52,242.3
33	Зам, тээврийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,091,171.8 24,362.8 1,066,809.0
34	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	525,351.8 380,106.1 145,245.7
35	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	424,032.5 69,935.2 354,097.3
36	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	723,002.5 664,422.0 58,580.5
37	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	118,430.3 82,685.2 35,745.1
38	Эрчим хүчний сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	298,411.0 102,217.8 196,193.2
39	Эрүүл мэндийн сайд Урсгал зардал Хөрөнгийн зардал	1,847,422.9 1,654,327.4 193,095.6

6.2.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилтийг олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
-----	-----------------------------	------------------------

1	Сангийн сайд	41,165.2
2	Боловсролын сайд	27,932.7
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	89,831.9
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	4,500.0
5	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	40,985.7

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 23
Бүгд: 116
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “7 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 24,209,847.5 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 85
Татгалзсан: 25
Бүгд: 110
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “8 дугаар зүйл.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 3,124,066.0 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 23
Бүгд: 110
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “9 дүгээр зүйл.“Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд 107,132.1 сая төгрөгийн эргэн төлөлтийг хийнэ.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 23
Бүгд: 110
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “10 дугаар зүйл.Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 1,596,178.2 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд 608,889.9 сая төгрөг хуримтлуулна.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 24
Бүгд: 110
78.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “11 дүгээр зүйл.2025 оны төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг доор дурдсанаар баталсугай:

11.1.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан зориулалтаар хийх дотоод зээллэгийн дээд хэмжээ 300,000.0 сая төгрөг хүртэл;

11.2.Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1,542,428.3 сая төгрөг хүртэл.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 26
Бүгд: 110
76.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “12 дугаар зүйл.Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,669,739.8 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 22
Бүгд: 110
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “13 дугаар зүйл.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2025 оны төсвийн жилд 3,500,000.0 сая төгрөг байна.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 21
Бүгд: 110
80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “14 дүгээр зүйл.Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 21
Бүгд: 110
80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН
НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН
НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД
ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ**

15 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	46,462.2
2	Баян-Өлгий	29,659.7
3	Баянхонгор	37,765.3
4	Булган	17,895.3
5	Говь-Алтай	29,685.2
6	Дундговь	19,308.7
7	Завхан	47,684.4
8	Өвөрхангай	36,362.0
9	Сүхбаатар	22,417.2
10	Төв	2,154.0
11	Увс	39,573.0
12	Ховд	14,041.6
13	Хөвсгөл	52,173.4
14	Хэнтий	40,849.4
15	Говьсүмбэр	9,282.0
Нийт дүн		445,313.4

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 21
Бүгд: 110
80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “16 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	11,755.7

2	Дорнод	448.0
3	Өмнөговь	1,769,143.3
4	Сэлэнгэ	2,187.4
5	Дархан-Уул	2,981.1
6	Орхон	145,266.8
Нийт дүн		1,931,782.2

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 21
Бүгд: 110
80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “17 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг, хот	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	14,505.7
2	Баян-Өлгий	14,026.3
3	Баянхонгор	23,502.4
4	Булган	15,258.1
5	Говь-Алтай	24,990.2
6	Дорноговь	55,686.9
7	Дорнод	30,428.3
8	Дундговь	18,250.4
9	Завхан	17,294.9
10	Өвөрхангай	17,299.9
11	Өмнөговь	60,770.5
12	Сүхбаатар	26,562.7
13	Сэлэнгэ	31,299.0
14	Төв	28,947.2
15	Увс	16,422.8
16	Ховд	30,475.8
17	Хөвсгөл	20,848.6
18	Хэнтий	23,761.1
19	Дархан-Уул	21,288.8
20	Улаанбаатар	60,333.0
21	Орхон	38,727.7
22	Говьсүмбэр	8,374.3
Нийт дүн		599,054.5

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 26
Бүгд: 110

76.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан:

**“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

18 дугаар зүйл.“Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 90

Татгалзсан: 20

Бүгд: 110

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “19 дүгээр зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 89

Татгалзсан: 21

Бүгд: 110

80.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “20 дугаар зүйл.“Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “21 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 20
Бүгд: 110

81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар 10.2, 10.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

“1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	6,927,203.2
1.1	Ажил олгогчийн төлөх шимтгэл	2,835,281.0
1.2	Ажиллагчдаас төлөх шимтгэл	2,285,157.4
1.3	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	14,543.1
1.4	Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	146.6
1.5	Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	294,322.0
1.6	Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	6,158.8
1.7	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,353.8
1.8	Бусад орлого	36,740.6
1.9	Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас	1,452,499.9
Нийт орлого		6,927,203.2

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 91
Татгалзсан: 19
Бүгд: 110

82.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 24
Бүгд: 110
78.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 95
Татгалзсан: 15
Бүгд: 110
86.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар 10.2, 10.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин, сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,514,881.8
1.1	Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	1,145,715.8
1.2	Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	353,036.7
1.3	Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	966,297.8
1.4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	49,831.5
Нийт орлого		2,514,881.8

” Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 91
Татгалзсан: 19
Бүгд: 110
82.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: “2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 20
Бүгд: 110
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 20
Бүгд: 110
81.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан *тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасан тухай мэдэгдэв.*

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 23
Бүгд: 110
79.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан *тогтоолын төслийг танилцуулав.*

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Амарбаясгалан: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 24
Бүгд: 110
78.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:13/

Уг асуудлыг 13 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т заасны дагуу Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан иргэн Батбаатарын Мөнгөнхишигээс агаарын бохирдол, утааны асуудлаар ирүүлсэн нийтийн өргөдлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулав.

Найм.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:16/

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:19/

Дагалдан гарсан:

3.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:19/

4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

6.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

7.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

8.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

9.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:20/

10.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:23/

11.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:23/

12.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг

танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:23/

13.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:23/

14.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:24/

15.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Л.Энх-Амгалан нар үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:28/

16.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:28/

Уг асуудлыг 13 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 126 гишүүнээс 110 гишүүн хүрэлцэн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРАЛ**

2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 28 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Нийт 85 гишүүн буюу 67.5 хувиар ирц хүрсэн байна.

Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 7 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 10 төсөл байгаа.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Тавдугаарт, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

Зургаадугаарт, “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Долоодугаарт, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ДНБ-ий бодит өсөлтийг 2025 онд 8 хувь, 2026-2027 онд 6.5 хувь байх, хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг 2025 онд 7.2 хувь, 2026 онд 5 хувь, 2027 онд 4 хувьд хүргэхээр тооцсон.

Мөн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025-2027 онд алдагдалгүй байхаар тооцож, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2025 онд 55 хувь, 2026 онд 50 хувь, 2027 онд 45 хувьтай тэнцэхээр байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын

дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Одоо Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Айн? Үг хэлэх байхгүй, асуулт л. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг нэмье. 5 гишүүнээр тасаллаа.

Мөнхтуяа гишүүн наад хурууныхаа хээг уншуулаад ирцдээ бүртгүүлчих. Шөнө яав, яагаад жаахан ууртай ирчхэв? Энэ техникийн хүн байна уу? 2 гишүүн яагаад үг хэлэх кноподоо орж чадахгүй байна? Очоодох доо. Хоцорч дарсан юм байна шүү дээ. Нэр авах хугацаа дууссаны дараа дараад байгаа юм байна. Нийт 8 гишүүн боллоо шүү. 8 гишүүнээр тасаллаа.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг ингээд дэгийн тухай хуулиар өөр сайд нараас бас асуулт асууж болохгүй болчихоод тэгээд би энийг далимдуулаад асуух гэж байгаа юм. Энэ оны хавар 5 сард Тэмүүлэн нарын гишүүний 17 гишүүний өргөн барьсан Малчны тухай хууль батлагдсан. Энэ Малчны тухай хуулиар малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тэр бололцоог нь нээж өгсөн. Энэ маш чухал хууль болсон юм.

Гэвч өнөөдрийг хүртэл Нийгмийн хамгаалал, гэр бүлийн сайд Энх-Амгалан ажилдаа ирээгүй байх шиг байна, өнөөдрийг хүртэл энэ хуулийн дагуу Засгийн газар журам гаргаж ажиллах ёстой. Өөрөөр хэлбэл, 7 сарын 1-нээс хэрэгжээд зөндөө олон хүмүүс орох ёстой байсан дээрээс нь ирэх он бүтэн энэ хууль хэрэгжих ёстой. Тэгээд 6 сараар ингээд хойш нь татаад явж байна. Тэгээд дахиад 1 жилийн хугацаанд энэ хэрэгжих ёстой. Энэ хууль дагасан журмаа яаралтай Засгийн газраар оруулж батлуулж, энэ хуулийг хэрэгжүүлэх тэр ажлаа хийгээч. Маш их олон хүмүүс 1 жил, 2 жил дутуу байдаг. Тэрнийхээ төлбөрийг төлөөд энэ нийгмийн даатгалын үлдсэн хугацаагаа нөхөөд ингээд тэтгэвэрт гараад, тэтгэврээ авах тэр боломжийг нь хаагаад л ингээд суугаад байх юм. Тэгээд Тэмүүлэн гишүүн бас нэлээн шаардаж хэлдэг гэсэн. Тэгээд үгийг нь тоохгүй ийм байдлаар ингээд яваад байна.

Энэ хуулийг маш их олон малчид хүлээж байгаа. Тэгээд энэ чуулган завсарлана, малчдаараа очих дээр ямар үгтэй очих гэж байгаа юм? Сайн шаардаарай.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Өчигдрийн хэлэлцүүлэг дээр буцаан дахин боловсруулах руу явсан Хавдрын шинэ эмнэлгийг санхүүгийн түрээсээр авах тухай асуудал байсан. Энэ дээр ойлголтын зөрүү байгаад байгаа юм гишүүд ээ. Энэ санхүүгийн түрээсээр авах эмнэлэг түр зууртаа ачаалал хөнгөлөх эмнэлэг. Энэ эмнэлгийг авах юм 100 ор нэмэгдэх юм Хавдар Судлалын Үндэсний төвд.

Бид нар Хавдар II-оо барих юм бол 600 ортой, үүдэл эс шилжүүлэн суулгах лабораторитой, бүх төрлийн эрдэм шинжилгээний лаборатори байгуулагдсан

бүхэл бүтэн цогцолбор эмнэлэг болох юм. Тугалган ханатай туяа эмчилгээний шугаман хурдасгуур тавих мэргэжлийн өрөө, 4 өрөөтэй тийм эмнэлэг байгаа юм.

Тэгэхээр Хавдар-II төслөө яг тэр чигээр нь хэрэгжүүлнэ гэдэг, хэрэгжүүлэх үү гэдгийг асуумаар байна? Хэрэгжүүлнэ гэдэг үг хэрэгтэй байна. Дээрээс нь энэ эмнэлгийг ямар нэгэн лоббинд автахгүйгээр Хавдар Судлалын Үндэсний төвд авч өгвөл сайн. Зүгээр ганц айж байгаа юм нь энэ эмнэлгийг авчхаад Хавдар-II төслийг зогсоочих вий дээ гэсэн айдас байгаа. Нийтдээ 47 гишүүн гарын үсэг зурж өгсөн. Тэр итгэл үнэмшил, дээрээс нь төсвийн ажлын хэсгийн гишүүдийнхээ итгэл үнэмшил бүх юманд нь найдаад Хавдар-II-оо барих нь хэвээрээ гэдэг амлалтыг аваад, санхүүгийн түрээсээр хавдрын шинэ эмнэлгийг авах асуудлыг дэмжиж байгаа. Тийм учраас энэ асуултад хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийг хэлэлцэж байгаа. Хэлэлцэх асуудлаа гишүүдийн дэлгэц дээр documents хэсэг дээр жагсаалтаар орчихсон байгаа гэдгийг та бүхэн маань анзаарч харахыг хүсэж байна. 7 асуудал хэлэлцэнэ.

Мөнхбаясгалан гишүүний асууж байгаа асуулт бол 4 дэх асуудал дээр яригдахаар байгаа. Мэдээж асуусан асуултад Сангийн сайд хариулт өгөх ёстой Төсвийн байнгын хороон дарга хариулт өгөх үү? Ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүн хариулт өгчихье. Дахин дахин яригдаж магадгүй учраас.

Нэр өгөх хугацаанд нэрээ өгөөгүй, нэрээ өгчхөөд 2, 3 дарж өөрөө буцаж гарсан тохиолдлууд гарсан байна Мөнхтуяа гишүүн ээ анхааралтай бай.

Г.Тэмүүлэн: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр би бас энэ 2025 оны төсөвтэй холбоотойгоор ер нь яг манай энэ Улсын Их Хурлаас, Засгийн газраас яг ямар хөрөнгө оруулалт, хөрөнгө санхүүжилтийг ер нь шийдэж байгаа юм бэ гэдэг талаар.

Тэгэхээр яг таны асуусан сая Хавдар-II буюу шинэ эмнэлгийг ирэх 3-4 жилийн хугацаанд барьж байгуулахын тулд нэгдүгээрт, ТЭЗҮ дээр нь 3 тэрбум төгрөг нь тавьчихсан байгаа. Энэ Засгийн газраас өргөн баригдсанаар орж ирсэн.

Дээрээс нь 10 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй санхүүжих 5 тэрбум төгрөгийг нь ирэх бүтээн байгуулалттай ажилд нь зориулж 5 тэрбум төгрөг тавьсан байгаад байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ бол Хавдар шинэ эмнэлэг-II дээр бол санхүүжилт нь 8 тэрбум төгрөг бол нэг талдаа байна гэсэн үг.

Дээрээс нь манай ажлын хэсгийн зүгээс, мөн ажлын хэсэгт ирсэн саналуудыг үндэслэж үзээд бид нар энэ ерөөсөө одоогийн байгаа ганц энэ хавдрынхаа ХӨСҮТ эмнэлэг дээрээ үйл ажиллагааг нь өргөжүүлэх, дээрээс нь орных нь тоог нэмэгдэх зориулалтаар өнөөгийн тулгамдаад байгаа энэ хавдрын нөхцөл байдалтай уялдуулж, энэ нөхцөл байдлыг богино хугацаанд шийдвэрлэх үүднээс хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөр гэсэн санхүүжилтийг төсөв дээр тусгаж өгсөн. Сая тогтоолын төсөл дээр бол орж ирнэ.

Тэгэхээр энэ бол ХӨСҮТ-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс, лизингийн нөхцөлөөр бол ХӨСҮТ маань өөрийнхөө өмчлөлд шилжүүлэн аваач. Ямар нэг байдлаар юу гэдэг юм, санхүүгийн түрээс, лизингээр орныхоо тоог нэмэгдүүлээч ээ гэсэн санхүүгийн механизм арга байдлыг нь бол нээж өгөөд, арга хэлбэрийг нээж өгөөд, дээрээс нь холбогдох санхүүжилтийг нь тавьж өгөөд, түүнд шаардлагатай тоног төхөөрөмж буюу 8 тэрбум, 6.8 тэрбум төгрөгийг тавьж өгсөн байгаад байгаа юм. Нийтдээ одоогийн ХӨСҮТ дээр 23.8 тэрбум төгрөг бол тавигдсан байгаа гэсэн үг. Нийт дүнгээрээ бараг гучин нэг, хоёр тэрбум төгрөг бол тавигдсан гэж бол хэлж болно хавдрын чиглэлээр.

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Өглөөний амрыг эрье. Тэгээд ямар ч байсан Засгийн газар, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал маань үнэнтэйгээ нүүр туллаа. Үнэнтэйгээ нүүр тулсан учраас арга байхгүй бид нар энэ Төсвийн хүрээний мэдэгдэлд ч гэсэн өөрчлөлт орж байна. 35.8 их наяд маань буураад 33.7 их наяд болж байгаа. Тэгээд энэ бол маш том дэвшил. Энэ татвар төлөгчдийн мөнгө болохоос Улсын Их Хурлын гишүүдийн мөнгө биш гэдгээ бид нар ойлгосон.

Тэгэхээр цаашид энэ улсын төсөв гэхээсээ илүү нийтийн төсөв гэж бас ярьж сурмаар байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан энэ нийтийн төсвийг яг нийтийнх нь төлөө зарцуулах руу илүү их том алхам алхсан гэж би бас бодож байгаа.

Ер нь бол нэг үгийг бас хэлмээр байгаа юм. Олон нийт чинь бол яг тэр урьд өмнөх шигээ зүгээр ингээд юмыг хараад л өнгөрөөдөг биш болчихсон гэдгийг санах хэрэгтэй. Тэгээд би зориуд хүний үгийг хэлье. Абрахам Линколин гээд АНУ-ын Ерөнхийлөгч асан, Америкийг үндэслэгчдийн нэг, эх орныхоо төлөө буудуулж амь насаа алдсан ийм хүн байгаа. Тэр хүний хэлсэн үг юу вэ гэвэл ард түмнийг хааяа нэг хуурч болно, эсвэл зарим нэгийг нь бүх л цагт хуурч болно. Гэхдээ бүх ард түмнийг бүх цаг үед хэзээ ч хуурч чадахгүй гэдэг үг байдаг. Тэгэхээр энэ үгийг би зориуд хэлмээр байгаа юм.

Тэгэхээр энэ улсын төсөв гэдэг нь бол татвар төлөгчдийн мөнгийг гарын салаагаараа урсгасан, савируулсан, элдэв төрлийн төсөл, арга хэмжээ, хэлэлцүүлгээр нүүр халхалсан ийм хулгай, луйвар явж байсныг бид үгүйсгэхгүй. Бүгд мэдэж байгаа, харж байгаа. Чадлынхаа хэрээр Улсын Их Хурал илрүүлээ, таналаа, хаслаа.

Тэгэхээр цаашид бол бас энэ чиглэл рүүгээ илүү их идэвхтэй ажиллаад, гишүүд ч гэсэн сүүлийн үед маш их идэвхтэй сав л хийвэл хасъя, таная гэдэг төсөл бариад гүйж байсан. Зарчмын зөрүүтэй санал. Тэгэхээр энэ дээрээ өшөө их идэвхтэй байж энэ ард нийтийн татвар төлсөн мөнгийг зөв зохистой зүйл рүү чиглүүлэхийн төлөө улам сайн ажиллах байх гэж найдаж байна. Тэгээд дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл зөв тооцоололтой, хэт оптимистик бус, орлогоо үнэн бодитоор дүгнэсэн, эрсдэлээ тооцсон ийм төсвийн төсөл, мөн төсвийн хүрээний мэдэгдэл орж ирнэ гэдэгт найдаж байна. Баярлалаа. Үг хэлэх боломжгүй учир энэ асуулт дээр авсан юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Төсвийг боловсруулахад бас ажлын хэсэг дэгийн тухай хуулиар зарим зардлыг нэмэгдүүлэхэд өөр зардлаас хаанаас хасах гээд байгаагаа өөрөө олоод ир гээд гишүүд рүү тийм дэгээр явахаар бас их төвөгтэй юм байна лээ. Уул нь энэ зардлуудыг хасах, алианаас нь зохицуулах асуудлыг уул нь Засгийн газар, мөн ажлын хэсэг бас ингээд ажиллах шаардлагатай.

Цаашдаа энэ дэгийн хуульд бас жоохон тодруулж оруулахгүй бол Их Хурлын гишүүд өөрсдөө яам нэг зардлыг нэмэхийн тулд өөр сайдын багцаас ч гэдэг юм уу хасаад чи өөрөө олоод ир гэдэг байдлаар зарчмын зөрүүтэй санал дээр асуудал тавихаар зөрчил үүсэх юм байна лээ.

Тийм учраас энийг цаашдаа энэ ажлын хэсэг дээр зарим нь богино хугацаа байсан учраас бас би бүрэн сайн ажиллаж чадсангүй гэдгийг хэлмээр байна.

Улсын Их Хурал өөрөө баталсан хуулиа хэрэгжүүлэх бас үүрэгтэй. Тухайлбал, би 2 санал дээр бол тухайлан хэлье. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль дээр нийт төсөв захирагч нарт нийт зардлынхаа 0.5 хувийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйдаа зарцуулна гээд хууль байгаа. Хувийн хэвшилд бүр 1.5 хувиар зарцуулах ийм хуультай.

Гэтэл энийг хэрэгжүүлэх нөхцөлийг байхгүй, зардлыг нь эндээ хүрч байсан түүх бараг байхгүй. Тийм учраас энийг ер нь цаашдаа яах юм бэ гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр би Сангийн яам яг энэ дээр холбоотойгоор сая энэ баталсан төсвүүддээ энэ хэмжээндээ зардлуудаа зарцуул гэдэг ийм чиглэлийг өгөх байдлаар энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах тал дээр яг ямар арга хэмжээ авах вэ? Нэг.

Хоёрдугаарт, тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой төрөөс хариуцна гээд байж байгаа. Энэ зардлуудаа ирэх жил 4 сарын 1-нээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдээд явна. Тэр үед нь төр нь өөрөө энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой уягдаж өгөх зардлуудаа өгч чадахгүй ээ гэдэг л ийм байдал руу л орох нь л дээ.

Тэгэхээр энэ төсвийн тодотгол ер нь 4 сарын 1-нээс өмнө ч юм уу ер нь яригдахаар ажлын хэсэг дээр яригдсан уу, яасан гэдгийг тодруулж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Энэ Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцээд байж байгаа. Тэгээд Эрдэнэбат гишүүний асуултад төсөв хэлэлцэх үеэрээ хариулт өгье дөө. Тэгэх үү? Тэгэхгүй бол энэ ажлын хэсгийн гишүүд бас яг хариулт өгөх гишүүд бүрэн алга байгаад байна. Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа шүү гишүүд.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Төсвийн хүрээний мэдэгдэл энэ жил 3.5 их наяд, ирэх жил 34 их наяд гээд төсвийн зарлагын хэмжээнүүд явж байна л даа. Нэг талаараа ингээд нарийн деталь маш ингээд ярьж байгаа нь өөрөө төсөв дээр маш сайн. Нөгөө талаараа энэ маань ийм 10 тэрбум доллар хүрэхгүй ийм эдийн засгийн хэмжээ, тоог л бид нар хэдүүлээ яриад байгаа. Энэ утасгүй чихэвч эйрпод гээд энэ

чихэвчний 1 жилийн борлуулалтын орлого нь 14 тэрбум доллар байдаг юм гэнэ лээ. Энэ 14 тэрбум доллар энэ бүтээгдэхүүний. Тэгэхэд бас бид нарын нөхцөл байдал ийм л байна.

Нөгөө талаасаа энэ төсвийн хэмжээ олон зүйлүүдийг ярихад бид нарын хувьд ямарваа нэгэн яг анхны түүхий эд, бараг л хэдүүлээ ийм хэдэн машин нүүрс гадагшаа гарч байна, нүүрсний үнэ яаж байна гэдэг ийм л эдийн засгийн тооцооллыг л энэ төсвийн хүрээ болоод төсвийн хэмжээнд бид нарын ярьдаг сэдэв бараг бүртгэлийн ажил энэ л болоод хувирчихсан ийм л нөхцөл байдалтай.

Төсвийн хүрээ болоод энэний өмнөх энэ чинь 4 дэхээ ч төсвийн хүрээг өргөн барьж байна. 9 сарын үед өргөн барьж байх үед эдийн засгийн өсөлт 8 хувь, тэр үед нүүрсний үнийг их эрэлт өндөр байх юм, байна хэмжээ өндөр байх юм байна гэж байсан. Яг одоо дахиад Ерөнхийлөгчийн хоригтой энэ асуудлыг ярилцаж байгаа үед дахиад л энэ төсвийн хүрээн дээр эдийн засгийн өсөлтийг 8 хувь гэж байна л даа. Энэ бол үнэхээр бас хэтэрхий бас өөдрөг тоо байна л гэж харж байгаа юм. Тэр үед Америкийн Ерөнхийлөгчийн сонгууль боллоо, Хятадын эдийн засгийн өсөлтийг өөдрөг бишээр авч байна. Нүүрсний үнэ тоо хэмжээг хоёуланг нь өөдрөг бишээр авч байна.

Тэгэхээр энэнтэй холбоотой бас олон олон зүйлүүдийг бид нар бас ингэж уг нь бас ярих, магадгүй 25 онд дахин дахин ярих шаардлага үүсэх нь ээ гэж бас үзэж байгаа юм.

Тэгээд төсвийг алдагдалгүй баталж байгаа гэж байгаа нь сайн. Гэхдээ АМНАТ-аас орох, Ирээдүйн өв санд орох хураамжийн хэмжээг 65 хувиас 45 хувь болгож байгаагийн чинь хооронд 1 их наяд төгрөг байгаа. Үндсэндээ 1 их наядын алдагдалтай төсөв баталж байгаа л гэсэн үг. Тэнд 65 хувиар суутгаж орох ёстой мөнгийг бид нар 40 хувь гээд л өөрсдийгөө хуураад л, тэнд 1 их наяд төгрөг нуугдчихсан л явж байгаа. Гэх мэтийн ингээд олон олон зүйлс энд байна.

Ер нь энэ төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой бид нар тал талдаа ойлгож мэдээлэл авмаар, мэдлэг авмаар нэг зүйл байгаад байгаа юм. Энэ ажлын хэсэг болоод Төсвийн байнгын хороон дээр энэ талын ямар мэдээллүүд байдаг юм? Ер нь төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг манайхан өндөр байхаар сайн гэж зарим хүмүүс энийгээ сурталчилдаг, төрийн зардлаар энэ чинь өөрөө бизнесүүдэд очдог энэ тэр гээд.

Тэгэхээр ер нь манай Монголын нийт эдийн засагт орж байгаа мөнгөний, хувийн хэвшилд орж байгаа мөнгөний хүртэл хэдэн хувь нь импортыг өдөөгөөд гадагшаа гарчихдаг вэ? Хэдэн хувь нь дотооддоо үлддэг вэ? Төсөв, тэр дотроо төсвийн хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь дотооддоо үлдэж байдаг вэ? Төсвийн урсгал зардлынх нь хэдэн хувь байдаг вэ? Үүнтэй харьцуулсан тэр үржүүлэгчийн нөлөө талаасаа бодитой манайд хийсэн энэ судалгаанууд ер нь яг юу байдаг юм? Үнэхээр энэ төсвийн зардал эдийн засагт ямар нөлөө үзүүлээд байгаа юм? Зарим хүмүүсийн тайлбарлаад байгаа шиг үнэхээр тэр энэний цаана чинь тоо, энэний цаана чинь үр ашиг, энэний цаана чинь өгөөж, энэний цаана чинь эдийн засгийн үзүүлэлтүүд дээр л бид нар тулгуурлаж энэ төсөв болоод төсвийн хүрээ олон зүйлүүдээ л ярих ёстой шүү дээ.

Тэгэхээр саяын тэр гурван тоон дээр, ер нь хувийн хэвшил төсөв, төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн урсгал зардал эдийн засагт, дотоод эдийн засагтаа ямар өгөөжтэй үлдэж, ер нь үүний эдийн засгийн үржүүлэгч нөлөөнүүд нь ямар байдаг юм? Энэ дээр манай яг энэ асуудал хариуцсан байгууллагууд, хариуцсан байгууллагууд, Байнгын хороо ажлын хэсэг дээр энэ дээр ер нь ямар дүгнэлтүүдтэй байдаг вэ? Тоотой, хувь проценттой зүйлүүдийг хэлж өгөөч.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж оруулж ирсэн сайд маань манай Гантөмөр сайд шүү дээ. Таны хажууд сууж байгаа хүн. Тэгээд би энэ Төсвийн хүрээний мэдэгдэл энэ бодлогын чанартай асуудал дээр бас хамтарч байгаа улс төрийн хүчний хувьд та бүхэн бас улс төрийн шийдэл гаргадаг байх гэж ингэж бодож байна, тэгж оруулж ирдэг байх гэж ингэж бодож байна. Хамтарсан Засгийн газрын нэг гол улс төрийн хүчин шүү дээ.

Тийм учраас та бүхэн уг нь яг иймэрхүү асуудлыг бас улс төрийн шийдэл гаргахдаа хоорондоо ярьчихдаг байвал зүгээр л дээ. Заавал энд зааланд орж ирээд ,үгүй ээ харин наад сайдын чинь оруулж ирсэн тоонууд шүү дээ.

Төсвийн зарлага бол 34 их наяд гэдэг чинь 10 тэрбум доллар. Өнөөдөр импорт бол нийт импорт бол 19-10 тэрбум доллар байгаа шүү дээ. Тэгэхээр энэ манайх шиг ялангуяа импортын хэрэглээ өндөртэй оронд бол төсвийн зарлага өндөр байх бол аюултай. Яагаад гэвэл тэр төсвөөс очиж байгаа мөнгө дийлэнх нь импортын хэрэглээний худалдан авалт хийгдэж байгаа. Яах вэ зүгээр ер нь бид нар төсөв дээр бас энэ хөрөнгө оруулалт дээр та асуугаад байна. Нэг зүйлийг бас ойлгох хэрэгтэй юм байгаа юм. Төсвийн зарлагын мөнгө ингээд улс руу хийгээд алга болчихож байгаа юм шиг ойлгоод байгаа юм. Үгүй. Энэ очиж байгаа хүмүүсүүдийн цалин, энэ тэтгэвэр, тэтгэмж, халамж чинь нэг дэлгүүрээс л ихэвчлэн худалдан авалт хийж байгаа шүү дээ. Тэр худалдан авалт хийж байгаа нь бол тэр компанийн борлуулалтыг нэмэгдэж байгаа. Компани эргээд татвар төлж байгаа.

Тийм учраас энэ төсвөөс гарч байгаа мөнгө бол эргээд л татвараараа ингээд л ороод л ирж байгаа мөнгө. Тэгэхдээ тэр дотор тэр борлогдож байгаа бүтээгдэхүүний харин дийлэнх нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа нь л өнөөдөр валютын нөөцийг сорох, валютын ханш өсөх ийм сөрөг үр дагаврыг бол автаж болзошгүй. Тэгэхээр яг энэ тооцоо, судалгаагаар бол манай Эдийн засаг, хөгжлийн яам хийж байгаа учраас Эдийн засаг, хөгжлийн сайдаас асуусан нь дээр байх.

Д.Амарбаясгалан: Нэмж ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүн чинь энд хариулах эрхгүй л дээ. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл хэлэлцэж байгаа. Та бол төсвийн ажлын хэсгийн дарга шүү дээ. Бүх ажлын хэсгийн дарга болчихсон юм уу? Гантөмөр сайд нэмж хариулах юм уу? Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан дарга хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Л.Энх-Амгалан: Төсвийн зарлагыг бууруулж байгаатай холбоотой эдийн засгийн өсөлт 8 хувьдаа хадгалагдах уу, импорт дээр ямар дарамттай вэ гэсэн асуултууд асуусан.

8 хувийн тооцоог бид хавар Төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахдаа хийсэн тооцоо. Төсвийн тодотгол болоод 25 оны төсөв боловсруулахтай холбоотой зарлага нэмэгдсэн. Эдийн засгийн өсөлтийн тооцоог ерөнхий эдийн засгийн, потенциал эдийн засгийн хүчин чадал боломжийн хувьд тооцдог тооцоо учраас төсвийн зарлага бага зэрэг өсөх, буурахад дагуулж хөдөлгөөд байхыг илүүд үзэхгүй байгаа.

Тийм болохоор 8 хувийн өсөлт манай улсын одоогийн хөрөнгө оруулалтын түвшинд, одоогийн хэрэглээний түвшинд зорилт болгоод тэрийг хангах бүрэн боломжтой гэдэг тийм тооцоо хийсэн учраас хөдөлгөөгүй байгаа.

Төсвийн зарлагыг 2.3 их наядаар бууруулж байгаа. Үүнтэй холбоотой.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Нэмэлт 1 минут.

Л.Энх-Амгалан: Нийт импортыг яг энэ төсвийн зарлага бууруулж байгаатай холбоотой 350 сая доллароор бууруулж тооцсон. Үүнтэй холбоотойгоор мөн төсвийн орлогын тооцооллыг дахин хийж, орлогыг бууруулж, давуулж бууруулсан байгаа. Нийт хэрэглээний сагс гэж байдаг, өрхийн хэрэглээний сагс. Тэр хэрэглээний сагсны 46 хувь нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг Цогтгэрэл гишүүний асуултад хариулахад. Тэрэнтэй уялдаад төсвийн зарлага ч, хөрөнгө оруулалтын зарлага ч 40-50, 60 хувь нь импортын зарлагад импортын бараа, бүтээгдэхүүн болох тохиолдлууд байдаг.

Гэхдээ ямар түвшний барилга, ямар түвшний хөрөнгө оруулалтууд хийгдэхээсээ хамаараад ямар хэмжээний импорт хийгдэх нь бас ялгаатай байдаг байгаа. Энэ бүхнийг төсвийн орлогыг тооцохдоо бүгдийг нь тооцоод энд дахин шинэчилж оруулж ирсэн байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ манай төсвийн төсөөлөл 3 жилийн ирээдүйн стратегийн зорилт гэж харж байгаа. Тэгэхээр нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээгээ ерөнхийдөө 2027 онд 30 хувь болгоно гэж зорьж байна.

Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух гээд байгаа асуулт маань болохоор манай тооцоолж байгаа стратегийн хамгийн зорилтот хувь маань хэд юм бэ? 25 хувь юм уу, 30 юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь манайхтай ойролцоо эдийн засагтай улсуудтай харьцуулахад бенчмарк/benchmark/ ер нь хэд байдаг юм бэ гэж асуулт байна.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан дарга 2 дугаар индэр дээрээс хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Төсвийн зарлага, эдийн засгийн хэмжээ хоёрын харьцаа КОВИД-оос өмнө манайх 31, 32 хувьтай, 30 хувьтай тийм байсан. КОВИД-ын жилүүдэд жаахан өссөн гучин гурав, дөрвөн хувьтай болсон. Энэ оны хувьд нэлээд өндөр буюу гучин долоо, найман хувьтай байгаа. Ирэх онд 35 хувь болж буурч

байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлээр үүнийг цаашдаа жил болгон үе шаттай бууруулах тийм стратеги баримтлаад тоонууд оруулж ирсэн байгаа. 33 хувьтай, 32 хувьтай болох тийм ойрын 3, 4 жилдээ тэгж буурна.

Ерөнхийдөө олон улсад улсуудыг эдийн засгийн хэмжээ, өрсөлдөх чадвараар нь байр эзлүүлэхдээ төсвийн зардал, ДНБ-ий 25 хувиас бага байвал тухайн улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар сайн байна гэж үздэг. Гэхдээ энэ хөгжиж байгаа улсуудын хувьд харьцангуй өндөр байх тохиолдлууд их байдаг. Манай хувьд 30 хувьтай байхад илүү зохистой гэсэн тийм жишиг тоо байдаг.

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэгээд гол нь стратегийн зорилт маань хэд юм бэ гэж асуусан шүү дээ. 30 юм уу, 25 юм уу яг хэд юм гээд байхгүй юу?

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ тийм ээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Ерөнхийлөгчийн тавьсан хоригтой холбогдуулж төсөв маань алдагдалгүй орж ирэх нөхцөл бүрдсэн. Мөн түүнийг дагаад Төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл бас өөрчлөлт орохоор ийм хэрэгцээ шаардлагатай болсон. Ер нь Ерөнхийлөгчийн хориг их олон зүйл дээр бас эерэг нааштай зөв зүйлүүдийн эхлэл болж харагдаж байгаа.

Тэгээд 22, 23 онд төсвийг алдагдалгүй баталъя гэж жил болгон төсөв дээр ярьдаг байхад мөрөөдлийн зүйл юм шиг санагддаг байсан. Хэн ч тоож авч хэлэлцдэггүй байсан. Тэгээд заавал Ерөнхийлөгчөөр хэлүүлэн барин, хориг тавиулан байж байж ингээд алдагдалгүй төсөв баталж орж ирж байна. Заавал ингэж хориг тавиулан байж алдагдалгүй төсөв батлах ийм хэрэгцээтэй байсан юм уу гэж. Хүсвэл бас алдагдалгүй төсөв баталж болдог юм байна гэдгийг бас харуулж байна шүү дээ.

Тэгээд цаашдаа ингээд дараагийн Их Хурал, дараагийн Засгийн газар, дараагийн Сангийн яам энэ том жишиг босгыг тогтоогоод алдагдалгүй төсөв оруулж ирэх ийм жишиг тогтоож байна гэж ойлгож байна. Энэнээс дордуулахгүй байх ёстой. Цаашдаа ашигтай төсөв оруулж ирдэг байх ийм жишгийн ийм эхлэл болж байна гэж энэ хориг энэ дээр зөв зүйлийн эхлэл болж байна гэж би харахаар байна.

Нөгөө талаар Төсвийн хүрээний мэдэгдэл дотор энэ 8 үзүүлэлтийн, 9 үзүүлэлтийн 8 дахь үзүүлэлт Засгийн газрын өрийн нийт хэмжээ ерөөсөө буурахгүй байгаа байхгүй юу. Бид нар яг ерөнхий байдлаар төсөв алдагдалгүй мэт харагдаж байгаа боловч дотроо яг агуулгыг нь хараад үзэхээр гол гол болсон Засгийн газрын өрийн хэмжээ чинь ерөөсөө буурахгүй ирэх 3 жилд 52 их наяд хэвээрээ л байгаад байгаа юм.

Тэгээд энэ 52.2 их наяд чинь яг Засгийн газрын бодит өрийг хэлж байна уу? Нийт бусад банкнуудын гэдэг юм уу, төрийн өмчийн компаниудын юм уу, хувийн хэвшлийнхний өр ороод байна уу? Энийг тодруулж өгөөч.

Нөгөө талаар энэ халамжийн, төсөв доторх халамжийн хэмжээ бас огт буурахгүй байгаа юм. Харин ч улам бүүр нэмэгдэж байна. 25 онд 2.5 их наяд, 26 онд 2.8, 27 онд 2.9 их наяд гээд. Тэгээд нөгөө халамжаас хөдөлмөрт гэдэг энэ зорилт чинь ирэх жилүүдэд хэрхэн яаж хэрэгжих юм бэ? Одоо байгаа халамжийн төрөл, хэлбэрүүдээс бууруулах, цөөлөх, хувийн хэвшил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэл дээр яаж ажиллах юм бэ? Энэ чинь энэ үндсэн бодлого, зорилттой чинь яаж уялдаж байгаа юм бэ гэдгийг энэ дээр хариулт өгөөч.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулах уу? Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан дарга хариулна. 2 дугаар индрийн микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Өр, ДНБ-ий харьцаа энэ хуулийн хязгаар нь 60 хувь байдаг. Тэгээд хавар Төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийг анх боловсруулж батлуулахдаа 60 хувийг 50 хувь, 45 хувь, 40 хувь гэж үе шаттай бууруулахаар тэгж оруулж ирсэн. Тэгээд сая энэ намар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт ороод төсвийн эндэх өрийн харьцааг нэрлэсэн дүнгээр тооцдог болсон. Нэрлэсэн дүнгээр тооцдог болсонтой бодит болон нэрлэсэн дүнгийн зөрүү нь ДНБ-ий 5 орчим хувьтай тэнцүү байдаг. Тэгэхээр тэр 5 хувиар буцааж нэмэгдүүлж 55, 50, 45 болгож оруулж ирж байгаа ийм л асуудал байгаа. Ерөнхий гүйцэтгэлээр Сангийн яамны хэлж байгаагаар хүлээгдэж байгаа гүйцэтгэл 42 хувьтай байна.

Гэхдээ өрийн тооцоон дээр олон зүйлийн эрсдэл нөлөөлж байдаг. Ханшаас эхлээд, ханш, инфляцаас эхлээд олон юм нөлөөлдөг. Тийм болохоор хууль зөрчигдөхгүй байх үүднээс тэнд бага зэрэг орон зайтай ингэж илүү төлөвлөж оруулж ирдэг байгаа шүү гэдгийг хэлье. Тэгэхээр гүйцэтгэл бол яг Сангийн яамны хэлснээр 42, 43, 44 хувьтай тэгж гарч ирнэ гэж бодож байна.

Нийгмийн халамж дээр ерөнхий төлөв, хуваарилалтыг яг төсөв дээр хийнэ. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр эдийн засгийнхаа нийт ямар хэмжээтэй, ямар хувь хэмжээнд хязгаарлаж явах юм бэ гэдэг асуудал оруулж ирж байгаа. Тэгэхээр ерөнхий явж ирсэн харьцаа ДНБ-ний 2.8, 9 хувьтай байдаг. Энэ удаад 2.7 хувьтай болгож оруулж ирсэн байгаа. Цаашаагаа үе шаттай буураад GDP-ийн 2.5 хувь ба багцаанд тогтвортой байх болов уу гэсэн тийм тооцоо хийж оруулж ирсэн байгаа. Доторх задаргааг нь төсөв дээр хийгээд явдаг байгаа.

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Төсөв маань өндөр байгаа. ДНБ-ийхээ 36 хувьтай тэнцчихсэн байгаа. Энэ бол бусад орнуудтай харьцуулахад хамаагүй өндөр шүү. Бусад орнууд бол 27, 28 хувьтай байгаа төсөв. Тэгээд төсөв маань 100 хувь бараг татвараас бүрдэж байна. Төсөв гэдэг бол татвар, дээрээс нь бусад орлого буюу хувьцаа, ноогдол ашгаас бүрдэх ёстой.

Гэтэл манай төсөв бараг 100 хувь татвараас бүрдээд байгаа юм. Төрийн өмчийн 123 аж ахуйн нэгжүүд байна. Орон нутгийн стратегийн ач холбогдолтой. Орон нутгийн чанартай төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд түүнээс болон тоог нь тоолоход тун төвөгтэй байна. Энэ 123 аж ахуйн нэгжүүдийг бүгдийг нь нээлттэй ХК

болгочих юм бол эдгээр компаниудаас бид нар ноогдол ашиг авах, мөн төсөв дээрээ татвараасаа гадна ноогдол ашиг олох ийм бололцоо нээгдэх юм. Тэгэхдээ зэрэг бид нар маш яаралтай энэ төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдээ ХК болгочих юм бол манай төсөв маань хамаагүй тэлнэ. Дор хаяж 10, 20 хувь тэлэх бололцоотой.

Тэгээд энэ дээр сая би өчигдөр энэ чуулганаар бол манай Мөнхтуяа гишүүний оруулсан нэг санал маань дэмжигдэж орж ирсэн. Энэ нь боловсролын салбарт төсвийн зардлын 6-аас багагүй хувийг зарцуулъя гэсэн энэ санал бол өчигдрийн чуулганаар дэмжигдэж орж ирсэн боловч өнөөдөр Байнгын хороогоор уначихсан байна. Бид нар төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг нээлттэй компани болгоод, эдгээр компаниуд нь ноогдол ашиг өгөөд төсөв маань томроод ирэхтэй нь зэрэг энэ боловсролынхоо салбарт бол хувь нэмэр оруулах, энэ боловсролын салбарыг 6 хувьд хүргэх бололцоо нээгдэнэ. Энэ 2 зүйлийг би асуумаар байна. Энэ нээлттэй компани болгох ажил хэр ер нь хурдацтай явж байгаа, ямар ажилд нэмэрлэх хэрэгтэй, дээрээс нь боловсролын салбарууд дээр зардлыг 6 хувьд хүргэх энэ боломж бололцоо, тоон дээр асуулт асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Пунсалмаа гишүүний асуултад хариулья.

Энэ өмнө нь Их Хурлын тогтоолоор 9 компанийг нээлттэй болгох ийм тогтоол гарсан. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах гээд эхлэхээр нөгөө листэд компани болгоход, ХК болгоход мэдээж нөгөө үнэлгээ хийгдэх ёстой, олон улсын аудит оруулах хэрэгтэй.

Тэгээд үнэлгээ нь яг олон улсын түвшинд үнэлэгдсэн, олон улсын аудит орсон ийм компани бол мэдээж нээлттэй компани болох процесс үргэлжлүүлнэ. Ингээд нөгөө ашиггүй ажиллаж байсан компаниуд нээлттэй компани болох гэхээр мэдээж нөгөө аудит хийлгэх зардлаа хаанаас шийдэх вэ, нөгөө андройтерынхоо зардлыг хаанаас шийдэх вэ гээд ингээд нээлттэй болгох процессыг давна гэдэг бол маш их бэрхшээлтэй юм байна.

Дээрээс нь зарим компанийн хувьд бол маш багаар үнэлэгдчихсэн. Тэгээд ийм бага хэмжээгээр үнэлэгдчихсэн компаниудыг нээлттэй компани болгоно гэхэд бол энэ өөрөө ашиггүй. Тийм учраас бол өчигдөр энэ Төрийн өмчийн компанийн хууль нь төрийн өмчийн компаниудыг энэ Төрийн өмчийн хуулиар бид нар нөгөө олон улсын аудит оруулах, дээрээс нь Засгийн газар аль аль компани дээр аудит оруулах вэ гэдэг жагсаалтыг батлах, энэ хуулийг баталж байгаагийн шалтгаан бол нөгөө зардлаа шийдэж чаддаггүй нөгөө компаниуд.

Тэгэхээр Засгаас шийдвэр гаргаад, ТУЗ нь өөрөө хуралдаад энэ Засгийн газар буюу хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа байгууллагаас үүрэг өгөгдсөний дагуу ТУЗ нь өөрөө хуралдаад, олон улсын аудит оруулаад, үнэлгээгээ хийлгээд ингээд бэлтгэл ажлыг хангуулах ажил руугаа орно.

Дээрээс нь бид нэг зүйлийг бодох ёстой. Ер нь ХК болгож байгаагийн давуу тал бол хөрөнгө мөнгө босгох, илүү орлоготой ажиллах чиглэл рүү, нөгөө орц, гарц

буюу ерөөсөө л байгаа нөөцийг хэрхэн хуваарилаад, гарцаа хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг энэ чиглэл рүүгээ ажиллах ёстой юм.

Гэтэл бид нар болохоор нөгөө ХК болгоно гэж хэлээд ашиггүй компаниудыг багаар үнэлчхээд тэгээд гаргачихаар энд ямар ч үр дүн гарахгүй байгаа юм л даа. Тэгэхээр энэ 122 компани гээд бодоод үзэхээр бол хоёрхон компани дээр, уул уурхайн хоёрхон компани дээр олон улсын аудит орсон. Өөр 3 компани дээр олон улсын аудит орсон. Тэр ерөөсөө бэлэн биш, үнэлгээ ч хийгдээгүй.

Тэгэхээр ерөөсөө ирэх онд бол бид нар энэ компаниудыгаа яг тэр олон улсын аудит оруулаад, зөвлөмжийнхөө дагуу бид нар нэгтгэх үү, нийлүүлэх үү, татан буулгах уу, листэд компани болгох вэ гэдэг сонголтуудыг нь яг тэр зөвлөмжийн дагуу хийгээд тэгээд листэд болгож байгаа компаниудыгаа Их Хурлаар орж, тогтоолоор албажуулаад, үнэлгээг нь хийлгээд ингээд дараагийн процессыг явуулна.

Татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх асуудлыг бол ирэх оноос хэрэгжүүлээд эхэлнэ гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд оръё.

11.08 цаг

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Баясгалан гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Баясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 1 саналын томъёоллоор, мөн хуулийн 42-ын дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу дахин санал хураалт явуулах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь үзсэн зарчмын зөрүүтэй 2 саналын томъёоллоор дахин санал хураалт явуулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох хууль, тогтоолын төсөлд нэмж тусган агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүд болон Төсвийн байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Эрдмийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Д.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Эрүүл мэндийн сайдаас асуух гээд байгаа юм. Энэ сая ажлын хэсэг дээр санал гаргаад 25 тэрбум төгрөгийг лизингийн эмнэлгийн шаардлага хангаж байгаа

эмнэлгийн үйл ажиллагаанд хавдрын зориулалтаар олгохоор төсвийн төсөлд тусгачихсан байгаа юм. Шинээр эмнэлэг барихад 450-500 тэрбум төгрөг болж байгаа юм байна. 600 ортой эмнэлэг барихад 1 орны үнэ нь ойролцоогоор 833 сая орчим. Одоо нөгөө шинээр ашиглалтад ороод бэлэн болчихсон байгаа 4 дүгээр эмнэлэг буюу Хавдрын эмнэлгийн яг хажуу талд байгаа эмнэлгийг тооцох юм бол 88 тэрбум. За яах вэ, 90 тэрбумаар тооцоод 120 ортой нь харьцуулаад үзэхэд бол орных нь үнэ нь 750 орчим сая төгрөг болоод байгаа буюу харьцангуй хямдхан байгаад байгаа юм. Тэгээд дээрээс нь яг Хавдрын эмнэлгийнхээ яг хажуу талд байгаа юм. Дээрээс нь цаг хугацааныхаа хувьд бол шинэ эмнэлгээ барьж байгуулах гэж байтал энэ чинь бас 5, 6 жилийн асуудал бас болох байх.

Тэгэхээр бид нар хавдрын өвчлөл ийм өндөр байгаа энэ тохиолдолд яг бэлэн хажууд нь ийм хямд өртгөөр бэлэн болчихсон байгаа эмнэлгээ аваад ашиглаад явчихвал одоо энэ 25 тэрбум төгрөгөө бас урсгал зардал болгоод хэн нэгний эмнэлгийн байрыг түрээслээд зардал гаргаж байхынхаа оронд түрээсэлж байгаа мөнгөө өөрсдөдөө хөрөнгө болгож үлдээгээд тэр 4 дүгээр эмнэлгийг авчихвал бас зүгээр юм уу гэж ийм санал хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя. Алга байна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Өчигдөр хэлэлцүүлгийн явцад асуултуудад хариултуудаа авчихсан учраас асуулт байхгүй байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Мэндсайхан гишүүн асуулт асуух уу? Асуулт давхацсан. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Энэ дагалдах хууль дээр энэ аж ахуй, юуны төрийн өмчит болон орон нутгийн өмчийн Энхбаяр гишүүн ээ хууль дагалдаж орж ирж байгаа юм. Тэгээд өчигдөр ингээд Учрал хэрэг эрхлэхийн даргын яриаг анхааралтай сонслоо л доо. Их Хурал ингээд олон улсын аудит хийлгэхгүй ч гээд байгаа юм шиг. Энэ чинь уг нь Засгийн газрын тогтоолоор шийдчих асуудал шүү дээ. Нэг бол энэ аж ахуйн нэгжүүд нь, энэ ТӨК-ууд нь Засгийн газрынхаа үгэнд орохоо больчихсон юм ч юм шиг энэ чинь. Тогтоолоор та нар энэ олон улсынхаа аудитаа хийлгэ ээ, энэ компани ингээд сонгож байгаад жагсаалтаа гаргаад та нар ингээд олон улсын хөрөнгийн бирж дээр гаргах гэж байна гээд тогтоол гаргаад энэ аудиттай холбоотой асуудлаа ингээд шийдчих юмыг өнөөдөр ингээд л Их Хурал дээр ороод л, Их Хурал тэрэнд нь дургүйцээд байгаа ч юм шиг ийм байдлаар энэ асуудлыг ингээд өнөөдөр, өчигдөр энэ Учрал гишүүн яриад байгаа байхгүй юу.

137 компани байна, 44 компани нь ашигтай ажилласан байна. Бусад нь бүгдээрээ алдагдалтай ажиллаж байна. Энэ 137 компани дээр 60 мянган хүн ажиллаж байна. 1 компани дээр ойролцоогоос 4-5 мянган хүн ажиллаж байгаа байхгүй юу. Тэгээд аудит хийлгэхгүй байна гэсэн юм яриад байгаа юм. Би тэгээд энэ Учрал сайдаас асуух гээд байгаа юм л даа. Та нар чинь энэ төрийн өмчит компаниудаа захирч чадахаа больчихоод байгаа юм уу? Бид нар Их Хурлын тогтоол дээр энэ төрийн өмчийн компанитай болон орон нутгийн өмчийн компаниудтай холбоотой сонсгол хийх асуудлыг хөндсөн шүү дээ бас. Энэ хооронд өр, авлагын асуудлыг нь шийд ээ гээд. Энэ чинь үндсэндээ 3 их наяд

төгрөгийн хоорондоо өгч, авалцсан зээлийн асуудал байгаад байгаа юм. 3 их наяд төгрөг шүү. Нэг ёсондоо алдагдалтай ажиллаж байгаа компаниуд нь ашигтай ажиллаж байгаагаасаа зээл авдаг, тэгээд алдагдлаа нөхдөг. Алдагдалтай ажиллаж байгаа мөртөө орон тоогоо цомхотгодоггүй. Өнөөдөр, өчигдөр ингээд л энэ Алтангэрэл сайдын хүний нөөцтэй холбоотой асуудал нь бид нар ингээд л бүрэлзүүлээд л хасна, нэмнэ гээд л яриад л байдаг.

Гэтэл энэ төрийн өмчид бай компаниуд дээр ажиллаж байгаа хүний тоо чинь замаа алдчихаад байгаа шүү дээ. 237 мянган төрийн албан хаагч дээр нэмэх нь төрийн компаниуд дээр 60 мянган хүн, орон нутгийн өмчийн компаниуд дээр дахиад 50-60 мянган хүн, нийтдээ 330-340 мянган хүн өнөөдөр татвар төлөгчдийн мөнгөөр цалин аваад амьдарч байна. Тэгээд энэ дээр нь зохистой харьцааны асуудал ч байдаггүй, таазны асуудал ч байдаггүй. Ингээд л иймэрхүү байдалтай л яваад байгаа юм. Би энэ дээр Учрал сайдын санал, бодлыг нь сонсчихмоор байна. Нэг бол энэ 137 компанийнхан захирлаа та нар энэ Байнгын хороон дээр авчирч байгаад бид нартай танилцуулмаар байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Учрал сайд өчигдөр хариулчихсан шүү дээ. Учрал сайд дахиад хариулах уу?

Н.Учрал: Төрийн өмчийн ба орон нутгийн өмчийн хуульд өөрчлөлт оруулсан. Тэгээд энэ өөрчлөлт бол зүгээр бас гишүүд зарим нь бас буруугаар ойлгоод байх шиг байна. Хөндлөнгийн аудитад бол Засгийн газар хувьцаа эзэмшигчийн хувиар оролцохгүй мэдээж. Мэдээж үндэсний аудитын байгууллага парламентад тайлагнаж байгаа учраас аудитын байгууллага ажлаа хийдгээрээ хийнэ.

Яагаад олон улсын аудит оруулах нь чухал вэ гэж яриад байгаа вэ гэхээр олон улсын аудит чинь хөндлөнгөөс зөвшөөрөгдсөн Монголд 4, 5 аудит байна уу тэр компаниуд хийчихвэл энэ компаниуд дараагийн түвшинд ажиллах бололцоо нь нээгдэнэ ээ л гээд байгаа юм.

Дээрээс нь бид нар асуудал тийм баримжаагаар биш, шууд санхүүгийн алдагдалтай ажиллаж байна, шууд татан буулгая гээд үнэ, тарифтай холбоотой энэ төрийн өмчийн компаниудыг буулгаж болохгүй.

Тэгэхээр нэгтгэх үү, нийлүүлэх үү, татан буулгах уу гэдэг асуудлыг олон улсын аудитын буюу хөндлөнгийн аудитын зөвлөмжид үндэслээд хийх ёстой. Мэдээж санхүүгийн аудит бол энэ Үндэсний аудитын байгууллага хийж байгаа.

Гэхдээ олон улсын энэ аудитуудын хийж байгаа гол ажил зөвлөмжүүд өгдөг. Тэр зөвлөмжүүдээ яаж цаашдаа алдагдлыг бууруулах юм. Одоо Ганхуяг гишүүний ярьж байгаа яагаад энэ орон тоо ингэж өсөөд байгаа юм, яагаад алдагдалтай ажиллаж байгаа компаниуд маркетингийн зардал гаргаад байгаа юм, яагаад алдагдалтай ажиллаж байгаа компаниудын захирлын унадаг машин нь хэвээрээ, авдаг цалин нь хэвээрээ байгаад компанийг алдагдалтай ажиллуулаад байгаа мөртөө, яагаад тэр алдагдлыг бууруулах төлөвлөгөө, оролдлого хийхгүй байгаа юм бэ гээд энэ болгоныг зүгээр Засгийн газар хувьцаа эзэмшигч юм гээд компанийн засаглал шууд халдаад Засгийн газар шийдвэр гаргаад яваад байх нь зохимжгүй.

Харин хөндлөнгийн аудитын зөвлөмж гаргуулаад хийвэл, гэтэл алдагдалтай ажиллаж байгаа компаниуд чинь өөрсдөө зардлаа гаргаад намайг шалгаач ээ, намайг хянаач ээ гээд хэзээ ч тэгж өөрсдөө шийддэггүй юм байна. Алдагдалтай ажиллаж байгаа юм чинь нэмэлт зардал гаргаад шийдье гэхээр бололцоо байдаггүй.

Тэгэхээр Засгийн газраас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа эдгээр компаниуд дээр олон улсын аудит оруулъя гээд жагсаалтыг нь баталчихвал ТУЗ-аараа оруулаад, ТУЗ нь шийдвэрээ гаргаад, аудит оруулаад жишээ нь холбогдох шийдвэрийг тэр хувьцаа эзэмшигчийн хувиар Засгийн газартай ярилцаад Төрийн өмчийн хороо шийдвэрлээд ингээд явдаг зөв жишиг рүү явъя.

Тийм учраас энэ тогтоо энэ хууль батлагдсанаараа бид ирэх оноос хувьцаа эзэмшигчийн хувиар Засгийн газар шийдвэрээ гаргаад аль аль компани дээр аудит оруулах вэ, ямар ямар шийдвэрүүдийг гаргах вэ гэдгээ шийдээд явна. Тийм ч учраас үүний дараа тэр орон тооны асуудал, хэмнэлтийн асуудал, бүтээмжийн асуудал яригдана.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 3 санал байна.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж дэгийн тухай хуулиар зохицуулсан байгаа.

Би зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалтын шаардлага хангасан барилгыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс /лизинг/-ийн нөхцөлөөр өөрийн өмчлөлд бүрэн шилжүүлэн авах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

68 гишүүн буюу 63.6 хувиар санал дэмжигдлээ.

Гүйцээн боловсруулах чиглэл авсан заалт байсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгасан санал.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

2.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

1.Төсөлд дараах агуулгатай 4 дүгээр зүйл шинээр нэмэх:

2.Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих;

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Зарчмын зөрүүтэй саналтай холбоотой дэмжсэн, эсрэг байр суурьтай тус бүр 2 гишүүн үг хэлэх боломжтой.

Ц.Мөнхтуяа гишүүн үг хэлье.

Ц.Мөнхтуяа: Ороод ирчихсэн байна тээ. Хүүхдүүдээс харамлаж, хүүхдүүдийн эсрэг гэмт хэрэг хийж байгаа гишүүдэд үнэхээр харамсаж байна. Сая Төсвийн байнгын хороогоор Батжаргал гэдэг гишүүний гаргасан саналын дагуу, Төв аймгаас сонгогдсон гишүүн юм байна. Манай багш нар бүгдээрээ үнэхээр гайхаж байна. Сая би пост оруулсан. Ийм хөөрхөн Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудаасаа харамлаж, төсөв харамлаж Төсвийн байнгын хороон дээрээ боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг буцааж Их Хурлын 62 гишүүний дэмжсэн саналыг унагаасанд үнэхээр харамсалтай байна.

Бид нар өнөөдөр аман дээрээ боловсрол тэргүүлэх салбар гэж их сайхан уянгалдаг мөртөө хачир дээрээ боловсролын салбар чинь уланд, уланд гээд нөгөө улныхан гээд та нар хэлчихсэн, нэрлэчихсэн юм байна лээ шүү дээ уланд байгаа. Өнөөдөр багшийн цалин чинь амьдралд нь хүрэлцэхгүй байна, хүүхдүүдийн чинь хувьсах зардал, хоолны мөнгө хаанаа ч хүрэхгүй байна. 400-хан доллар жилд хүүхдэд зарцуулаад ингээд инээлдээд сууж байгаагаасаа ичээрэй та нар. Үнэхээр ичээрэй. Би бол ичиж байна та нарын өмнөөс. Тэгээд тэр өчигдөр санал өгсөн 62

гишүүнээ би 1, 1-ээр нь Монголын багш нарт таниулна. Та нар дэмжээрэй. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дэмжсэн байр сууриар Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Тийм ээ улс орныхоо хөгжилд, салбаруудынхаа хөгжилд их хайртай улсууд олон болчихоод байгаа юм. Тэгэхдээ би тэр утгаар нь яримгүй байна. Би тэр утгаар нь яримгүй байна. Их Хурлын гишүүнийхээ хувьд өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийнхаа дагуу саналаа илэрхийлсэн. Байнгын хороонд оролцсон гишүүдийн маань гуравны хоёроос дээших нь дэмжсэн ийм л зүйл. Энэ бол ардчиллын зарчим, явдаг зүйл гэдгийг зориуд хэлмээр байна.

Боловсролын салбарыг Монгол Улс тэргүүлэх салбар гэж үзэж, бодлогоо ч, төсвийн хуваарилалтаа ч хийж явж байгаа гэдгийг би зориуд хэлье. Өнөөдөр Монгол Улсын төсвийн урсгал зардлын 19 хувийг боловсролын салбар маань хөрөнгө оруулалтынхаа зардлын 12 хувийг эзэлж явж байгаа. Нийлбэр дүнгээрээ 13.5 хувьтай байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагаар нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийг тодорхой хувиудаар бууруулж явахаар бид төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллөө баталж явж байгаа. Энэ жилийнх 35 хувьтай, ирэх оных 33, 27 оных 32 гээд. Гэтэл нийт ДНБ-ий 6-аас доошгүй гээд хэлчихээр зэрэг салбар хоорондын тэнцэл, мөн дээр нь ирээдүйн хөгжлийн энэ зохистой хөгжлийн чинь асуудалд бас асуудал байна гэж үзэж зориуд оруулсан.

Тийм учраас энэ боловсролын салбарын эсрэг гэдэг юм уу, үр хүүхдийнхээ эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ биш. Энэ бол салбаруудынхаа зохистой хөгжлийн асуудал. Ирээдүйд бас энэ улс орны хөгжлийг хангаж чаддаг, энэ төсвийнх нь орлогыг нэмэгдүүлж чаддаг, энэ иргэдийнх нь амьжиргааг дээшлүүлж чаддаг тэр салбар руугаа чиглүүлдэг тэр хөрөнгө оруулалтынх нь хэмжээ бас зохистой хэмжээгээрээ явах ёстой юм. Энэ л зарчим үүднээс асуудалд хандсан гэдгийг зориуд хэлье.

Монголын төр боловсролынхоо салбар, үр хүүхдүүдийнхээ төлөө бодлогоо ч тэр, төсвөө ч тэр бүрэн чиглүүлж явж байгаа гэдгийг зориуд хэлмээр байна. Одоо ингэж хэдүүлээ салбар салбар дээр тусгайлсан төсвийн харилцаа, тусгай шаардлагууд тавиад явчих юм энэ чинь энэ салбаруудын, улс орны одоо ба ирээдүйн хөгжилд бас зохистой хөгжлийнх нь тэнцэл алдагдах ийм нөхцөл байдал үүснэ. Энэ үүднээс нь асуудалд хандсан гэдгийг зориуд тэмдэглэж хэлье. Тийм учраас Төсвийн байнгын хорооны саналыг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Өөр? Галбадрах гишүүн үг хэлье.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би өчигдөр чуулга дээрээ энэ саналыг дэмжсэн. Тэгээд би өөрөө гишүүнд хэлж байсан. Ер нь ДНБ-ий 6 хувь гэдгээ аваад, зүгээр нийт зарлагын 18 хувь гэдгээрээ ороод ирвэл бид нар бас боломж нь өшөө нэмэгдэх байх гэж байсан. Ер нь бид нар НҮБ-ын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээндээ энэ зардлыг 18 хувь,

бүүр энэнээс бага байлгахгүй тал дээрээ та бүхнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Би чуулган дээр ч гэсэн өмнө нь хэлж байсан, Байнгын хороон дээр ч гэсэн хэлж байгаа. Ер нь бид нар боловсрол дээрээ л гол хүчээ тавих ёстой, гол анхаарах ёстой юм. Төсөв энэ алдагдалгүй болж байгаа, эдийн засаг сэргэж байгаа, өсөж байгаа энэ үед бид нар хүнээ бэлдэж авах ёстой. Мега төслүүд хийнэ гэж байна. Энэ мега төслүүд маань хүнгүйгээр хийгдэхгүй ээ. Монгол хүн өөрсдөө Монгол инженерүүд, техникийн ажилтнууд хийх ёстой. Энэ суурь боловсролыг, энэ ерөнхий эрдмийн боловсролыг маш чанартай өгөөд их, дээд сургуулиудыгаа ингэж дэмжиж явахад энэ хэрэгтэй. Энд суралцагсдын эрх маш их зөрчигдөж байгаа, багшийн эрх зөрчигдөж байгаа, би бүүр жишээ гаргаад хэлсэн. 1 ангид 40 хүүхдээс дээш бүлэгтэй ангид нийт 214 мянган хүүхэд сурч байна. 1800 хүүхэд даац нь хэтэрчихсэн сургуульд нийт 318 мянган хүүхэд сурч байна. Энэ бүгдийн эрхийг хамгаалахын тулд бид нар дорвитой хөрөнгө оруулалтыг боловсролдоо хийх хэрэгтэй байна гээд. Тэгэхээр энэ ойрын энэ жилүүдэд ялангуяа бид нар бүүр боловсрол энэ ойрын 3, 4, 5 жилд нэлээн том хөрөнгө оруулалтыг хийх нь зүйтэй. Үүний тулд би энийг дэмжиж байна. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн. Мэдээж гишүүдийн гарч байгаа санал чухлыг бас ойлгож байгаа.

Гэхдээ энэ чинь төсөв, санхүү бодлогын асуудал дээр өөрөө энэ чадамжтай, боломжтой эсэхээ бид харж байхгүй бол бас хамаагүй шийдвэрийг сэтгэлийн хөөрлөөр, бас зарим талаар улс төрийн попролоор аваад явчихдаг. Эргээд хэрэгжихгүй Улсын Их Хурал, Засгийн газар хүнд байдалд орох аюул бас байдаг учраас энэ мэргэжлийн Байнгын хороо асуудалд ингэж дахин дахин хандаж байгаа гэж ойлгож байгаа.

Төсвийн байнгын хороон дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Тийм, Төсвийн байнгын хорооны гишүүд Мөнхтуяа гишүүний гаргасан энэ саналыг бол зөв гэдгийг бүгд ойлгож байгаа. Энэ бол зөв санал. Угаасаа энэ НҮБ-ын тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичигт ч байж байгаа, бидний хөгжлийн бодлогын баримт бичигт ч байж байгаа. Ер нь боловсролын салбарын баримт бичгүүд юу гэж байдаг вэ гэвэл төсвийн зарлагын 20 хувь хүртэл гэж байдаг байхгүй юу. Байгаа.

Тэгэхээр энэ гаргасан санал нь өөрөө бодлогын баримт бичигт биш 2025 оны төсвийн хэрэгжилтийг хангах тогтоол дээр орчхоод байгаа байхгүй юу. Тийм учраас хүүш 25 оны хэрэгжилтийг хангах “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд оруулчхаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь нөгөө бид нар 25 оны төсвийн хэрэгжилтийг хангах тогтоол болохоос биш 26, 27 оны бодлогын баримт бичиг биш байхгүй юу. Тэр талаас нь л гишүүд үзээд энэ бол тогтоолд одоо 26 оны юуг тусгах нь зохимжгүй байна л гэж үзсэн хэрэг байхгүй юу. Тэрнээс биш энэ асуудлыг тэр бодлогын баримт бичгүүдэд оруулах энэ тэр дээр бол ямар ч дургүйцэх бололцоо байхгүй.

Яагаад гэвэл Монгол Улс өөрөө боловсролын салбарын хүрээнд хөгжиж байгаа орнуудын энэ зорилтот түвшнийг хүлээн зөвшөөрчихсөн. Төсвийн зарлагын 20 хувь хүргэх ёстой. Тэгээд энэ тал дээр бол би Төсвийн байнгын хорооны гишүүд эсэргүүцэж байгаа юм байхгүй гэж бодож байна.

Уг нь бол зүгээр энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол руу нь оруулчихсан байсан бол харин энэ болох байсан байж магадгүй. Тэгээд энэ нөгөө дунд хугацааны хөтөлбөрийн өмнөх дээр биш ээ, таны орсон чинь 25 оны төсвийн хэрэгжилтийг хангахад орчихсон байхгүй юу. 25 оны төсвийг хэрэгжүүлэх тогтоолд орчихсон байхгүй юу. Тэн дээрээ асуудал байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Засгийн, “2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байж байгаа юм Мөнхтуяа гишүүн ээ, Мөнхтуяа гишүүн. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Тэгээд та яг энэ тогтоолын төсөл дээр санал гаргачхаад энэ өөрөө ирэх оныхоо төсвийн бодлоготой шууд зөрчилдөж байгаа учраас дэмжиж чадахгүй байна гээд энэ Төсвийн байнгын хорооны гишүүд чинь тайлбар хийгээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг, үгүй ээ энэ ойлгуулахгүй байна шүү дээ. Та хар аа хэрэгжихгүй заалтыг хүчээр тогтоолд оруулах гэж ингэж үзээд байна. Түүнээс ярьж байгаа бодлого, зарчмыг чинь эсэргүүцэж байгаа хүн алга байна гэж байна шүү дээ. Энэ чинь өөрөө, та болохоор 26 оноос эхэлж ингэж хэрэгжүүлэх ёстой гэж ярьж байгаа мөртөө 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол руу санал хийчхээд, тэр санал чинь хэрэгжих боломжгүй байна гэдэг тайлбарыг хэлэхээр зөрүүлж та боловсролын салбарыг бодлогоор дэмжсэнгүй гэдэг улс төр хийгээд байгаа байхгүй юу. Тэгээд улс төр хийх энэ асуудлыг ярих чинь өөрөө зарчмын хувьд байж болох зүйл.

Гэхдээ бидний алдаад байгаа зүйл манай гишүүдэд хаана, хэзээ, яг юун дээр вэ гэдэг дээрээ алдаад байна шүү дээ. Тэгээд Их Хурлынхаа гишүүдийг их боловсролын салбарыг дэмждэггүй юм шиг байдлаар тайлбарлаж, танхим дотор улс төр хийж, Улсын Их Хурлын гишүүний саналаа өгөх бүрэн эрхэд халдаж байгаа энэ байдал чинь зохисгүй юм. Улсын Их Хурлын гишүүн өөрөө Ёс зүйн дүрэм, дүрмээр хүлээсэн үүрэг байдаг гэдгийг дандаа бодно шүү.

Түүнээс энд бодлогыг нь дэмжихгүй байгаа зүйл алга байна шүү дээ. 26 онд гэж ярьж байгаа мөртөө 25 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ рүү хүчээр оруулах гэж дайраад байгаа байдал чинь зарчимтай нийцэхгүй байна гэж байна шүү дээ. Төсвийн төсөөлөл, төсвийн хүрээг чинь бид сая түрүүчийн түрүүчийн буюу өнөөдрийн нэг дэх асуудлаар хэлэлцээд дуусчхаад байна шүү дээ. Энэ чинь дараачийнх нь асуудал дээр орж ирчхээд явж байхад чинь наад хэлэлцэж байгаа асуудлынхаа дараалалтай бүрэн танилц л даа. Юмаа гүйцэд унш л даа.

Тэгэхгүй тэгээд Улсын Их Хурлыг, Улсын Их Хурлын гишүүдийг байдалд оруулаад сууж байдаг энэ байдал чинь зохимжгүй байна. Хөндөж байгаа сэдвийг чинь буруутгаж байгаа зүйл биш байна. Хэзээ хөндөх вэ, юун дээр хөндөх вэ энэ бүх зүйлээ жоохон тогтож уншиж харцгаа гэдгийг бас сануулж хэлье. Тэгээд энэ танхим дотор дур зоргоороо бас ингэж аашилдаг байдлуудыг бас таслан зогсоох ёстой шүү. Монголын ард түмнийг төлөөлж байгаа, ёс зүйгээр, зарчмаар

манлайлах үүрэгтэй гишүүд энд сууж байгаа гэдгийг дандаа бодож ажиллана шүү. Түүнээс дур дураараа аашилдаг танхим бол энэ огт биш.

Ингээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

3 гишүүн буюу 58.2 хувиар санал дэмжигдлээ.

3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал байж байгаа тийм ээ? Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа эхлээд үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Энэ анхны томьёолол нь Батжаргал гишүүний оруулсан санал юм байна лээ. Тэр томьёоллоор 25 онд магадлал нь, дүн нь өсөж чадаагүй, 25 оны төсөвт орж чадаагүй тэр дүнг л магадлал хийлгэх тухай заалт байгаа юм. Энэ Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолоор заавал үүрэг авч хийх ажил биш л дээ. Засгийн газар өөрөө хийж хэрэгжүүлэх үндсэн чиглэл, үндсэн ажил нь юм байгаа юм.

Миний санаа, энэ оруулаад байгаа санаа өөр. 2023 оны, 22 оны 11 сарын Улсын Их Хурлын тогтоолоор 2023 оны эхний хагас жил хүртэл улсын төсөвт тусгагдсан, магадлал хийгдсэн өсөлт гарсан ажлуудад Үндэсний аудитын газар аудит хийсэн байгаа юм. Энэ аудитын дүнгээр 321 төсөл, арга хэмжээнд аудит хийхэд 77.5 тэрбум төгрөгийн магадлалын нэмэгдэл буюу үндэслэлгүй нэмэлт байна гэж үзэж дүгнэлт гаргасан. Энийг хассан байдаг. Энэ цагаас хойш төсөвт орж байгаа дүнгүүд өөрөөр хэлбэл, 2023 оны сүүлийн хагас жилээс хойш төсөвт нэмэгдсэн магадлалын дүнгүүд дээр аудит хийгдээгүй явж байгаа өнөөдрийг хүртэл.

Тэгэхээр энэ хугацаанд өнөөдөр 25 оны төсөвт орсон 600 гаруй төсөл, арга хэмжээнээс өмнө нь магадлал хийгдэхдээ хийгдсэн дээр нь аудит орчихсон дүнгээ хасаад, магадлал дээр аудит ороогүй байгаа бүхий л ажлууд дээрээ дахин аудит хийгээч ээ л гэж байгаа юм. Дахин аудит хийе ээ гэж байгаа юм. Энэ нь өөрөө юуг ямар ач холбогдолтой вэ гэхээр цаашдаа бид нарын энэ төсвийн тэлэлтийг бий болгоод байгаа, энэ төсвийг өсгөөд байгаа гол асуудал чинь ерөөсөө энэ магадлал байна гэж харж байгаа 70, 80 тэрбум төгрөгөөр өнөөдөр энд яригдаж байгаа олон асуудлыг бид нар шийдэж чадна шүү дээ. Төрийн албан хаагчдынхаа үйл ажиллагааны зардлыг хасаад төсөвт өртөг нь хүрэхгүй ядаж байхад эргээд

өмнөх онд нэмэгдсэн энэ магадлалын дүнгүүд дээр огт юм хийдэггүй, огт анхаардаггүй, тэгээд энэ нь эргээд төсвийн тэлэлт болоод байна гээд амьхандаа би Засгийн газарт туслах санаатай л санал оруулаад байгаа юм. Харамсалтай нь энийг ойлгож л баймаар юм. Яагаад ингээд буцаагаад байгааг би ойлгохгүй байна.

Би ганцхан жишээ хэлье. Өмнө нь хэлсэн жишээгээ дахиад хэлье. Магадлалаар 2020 онд анхны төсөв нь 64 тэрбум, 94 тэрбум байсан ШУА-ийн цогцолбор хоёрхон жилийн дотор магадлал хийгээд 154 тэрбум болчихсон. Энд аудит ороогүй явж байгаа. Одоо яг анхны хувилбараар Батжаргал гишүүнийхээр орчихоор зөвхөн 25 оны төсөв дээр нэмэгдэх дүнгүүд нь ороод, өмнөх дүнгүүд нь орохгүй болчих гээд байгаа юм.

Тийм учраас магадгүй Батжаргал гишүүний гаргасан анхны томъёолол бол 25 оны төсөвтэй холбоотойгоор авах арга хэмжээний санал дотор орж болж байгаа юм. Би бол Засгийн газарт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн нэгэнт санал гараад, томъёолол нь тодорхой болоод, Улсын Их Хурал, Байнгын хороогоор санал хураагдчихсаны дараа тэгэх байсан, ингэх байсан гэж хэдүүлээ яримааргүй байна.

Өнөөдөр бидэнд орж ирчихсэн байгаа саналын томъёолол өөрөө 2025 оны улсын төсөвт тусгагдсан бүх барилга, байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн, зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жил тайлагна гэж байна шүү дээ. Энийг чинь Сангийн яамнаас, холбогдох байгууллагуудаас юу гэж тайлбарлаж байна вэ гэхээр энэ ажлыг 25 оны төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалтад бүхэлд нь хийсэн тохиолдолд ирэх оны эхний хагас жил 1 ширхэг ч хөрөнгө оруулалтын ажил хөдөлгөх боломжгүй болно гэж байгаа юм. Аудитын байгууллагаар магадлуулах, хууль хяналтын байгууллагаар шалгуулах.

Гэтэл Үүрийнтуяа гишүүний анхны гаргасан санал нь болохоороо өмнө нь магадлал хийлгэсэн хөрөнгө оруулалтын ажлуудад шалгалт хийгээч ээ гэж байгаа юм. Гэтэл энд чинь нөгөө цаг хугацааны чинь томъёолол буруу орж ирчхээд, өнөөдрийн энэ санал хураах гэж байгаа томъёолол дээрээ бид ярих ёстой байхгүй юу. Энийгээ Байнгын хороо ажлын хэсэг дээрээ маш сайн ярьж байж орж ирэх байсан. Гэтэл чуулган дээр одоо ингэж орж ирчхээд бид өнөөдөр энэ орж ирчихсэн байгаа томъёолол дээр редакцын засвар хийх ч боломжгүй сууж байна шүү дээ. Тийм, энд чинь 2025 оны улсын төсөвт тусгагдсан гэж байна шүү дээ. Тийм. Батжаргал гишүүн энэ дээр тайлбар хийгээч.

Ж.Батжаргал: Үүрийнтуяа гишүүний гаргасан саналыг буруу гэж үзэхгүй байгаа юм.

Гэхдээ 2025 оны төсөвт өртөг нь өсөөд магадлал хийгдчихээд байгаа төсөл, арга хэмжээнүүдийн тэр өсөлтийн хэсэг нь орж ирж чадаагүй юм. Энэ нь бараг 300-гаад тэрбум төгрөг байна гэж манай Барилгын яаман дээр судалгаа юмнууд нь гарсан юм. Энийг дагаад олон төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удаашраад байгаа юм.

Тийм учраас энэ ажлыг богино хугацаанд урагштай явуулахын тулд бүгдийг нь 1 дүгээр улиралд багтаагаад, магадлалыг нь дахиж нягтлаад, аудитаар оруулаад, санал, дүгнэлтээ оруулаад ирээч ээ гэдэг ийм үндсэн зорилгоор энэ Засгийн газарт өгөх чиглэл өгөх тухай тогтоолын 1.3 дахь заалт орсон юм.

Гэтэл Үүрийнтуяа гишүүн маань тэр заалтыг маань шинэчлэн найруулаад 25 оны төсөвт тусчихсан төсөл, арга хэмжээнүүд дээр аудит хийхээр болгочхож байгаа юм. Би ер нь Улсын Их Хурлыг, Засгийн газрыг эргэлзээтэй юм оруулж ирээд баталчхаж байна гэж ойлгохгүй байгаад байгаа. Тодорхой кэйс байгаа бол тэрийгээ хууль, хяналтын байгууллагадаа л тавих ёстой.

Тийм учраас энэ боломгүй байна. Би Үүрийнтуяа гишүүний гаргасан санал миний тэр анх гаргасан саналтай шинэчлэн найруулж оруулж ирээгүйсэн бол хоёулаа зэрэгцээд явахад тогтоолд асуудал байхгүй. Гэтэл 25 оны төсөвт орчихсон юман дээр нь аудит хийнэ гээд, орж чадаагүй юман дээр нь аудит хийх юмыг нь хаачхаж байгаа байхгүй юу. Байхгүй болгочхож байгаа юм.

Тийм учраас үүнийг Төсвийн байнгын хороон дээр ярьж, дэгийн хуулийн дагуу Төсвийн байнгын хороо дэмжээгүй юм. Тийм учраас Төсвийн байнгын хорооныхоо саналыг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсэж байна. Ингэж байж хэдүүлээ энэ улс оронд хэрэгжиж байгаа бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээнүүдээ цаг алдалгүй урагшлуулах шаардлагатай байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн. 1 гишүүн одоо үг хэлэх дэгтэй.

Ж.Ганбаатар: Үгүй ээ энэ Байнгын хорооны санал, дүгнэлтээс үг хэлнэ гээд 3 гишүүн нь байсан. Та нөгөө өнгөрөөгөөд явчихсан учраас үгээ авч байгаа шүү. Тэгээд би нэг зүйл хэлье. Энэ Засгийн газар энэ орлого талаа гүйцээх талаар анхаараарай 34 их наяд шүү. Эдийн засгийн яам, Сангийн яам, тэр Ганбат дарга, бүх хүмүүс энэ орлого талаа яаж гүйцээх юм. Би ер нь гишүүн болсноосоо хойш ер нь зарлага талд их үг хэлдэггүй юм л даа. Орлого талдаа анхаарах хэрэгтэй. 34 их наяд төгрөгөө яаж олох вэ? Энэ хүмүүс ингээд баахан санал гаргаад явж байдаг. Тэгсэн оны дундуур тодотгоно гээд зарлага нь хасагдаад явчихдаг юм шүү. Тэгээд баахан л хоорондоо маргалдаад л баахан бичиг сачиг болоод л байдаг юм.

Тэгээд өнгөрсөн онуудад анх удаа бид төсвөө орлого нь давсан, түүхэндээ анх удаа хэдэн он билээ гэдгийг санаж байгаа байх. Тэгээд орлогоо давуулах талаас нь яаж уул уурхайн бүтээгдэхүүнүүдээ энэ төлөвлөсөн хэмжээнд нь зөв экспортлох вэ, яаж аж ахуйн нэгжүүдийнхээ энэ татвар төлөх сонирхлыг бүрдүүлэх вэ, нэмэгдүүлэх вэ, татвар төлөх бааз суурийг яаж нэмэгдүүлэх вэ гэдгийг Засгийн газар их сайн төлөвлөх хэрэгтэй.

Тэгэхгүй бол жилийн жилд энэ гишүүдийн гаргаж байгаа санал уул нь бол нийгмийн талын асуудлуудыг бид орлого олж байж л шийдвэрлэнэ шүү дээ. Орлогоо олж байж л бид шийдвэрлэнэ. Тэгэхлээр би одоо ингээд энд өнөөдрөөс ингээд энэ төсөв хэлэлцэж байгаа хугацаанд харж байхад орлого гүйцээх тал аягүй сул байгаа, аягүй сул байгаа.

Тэгэхээр ингээд асуулт асуугаад орлого талыг нь асуухлаар ингээд 70 гаргасан юмыг чинь 80 гаргаж л таараа. Тэгээд ийм байдалтай уучлаарай. Аягүй бол он дөнгөж эхлээд л юм аягүй тэгээд л төсвөө тодотгоно гээд л баахан зардал, энэ бараг сар хагас хэлэлцсэн энэ их олон хүмүүсийн ажил, хөдөлмөр тэгээд л үргүй болно шүү. Орлого талд чинь би тусалъя, зэсээ зараач ээ, нүүрсээ биржээр зараач ээ, зэсээ биржээр зараач. Тэгээд өшөө Монголд мөнгө олох боломжууд их байна шүү дээ. Үгүй ээ тэр Алтанбулагийн боомтоо хар. Монгол Улс тэр архи, зарим хүмүүс гайхаж байна лээ шүү дээ. Хэчнээн их архи уудаг юм бэ гэж. Тэр юуны байцаагч нар нь гэж байна лээ шүү дээ. Тэр гаалийн байцаагч нар нь. Тэр Сангийн яам тэр мөнгөө олж аваач тэр. Энд тэнд, энд тэнд Монгол Улсад мөнгө их байна. Үгүй ээ тэрийгээ олж аваад тэгээд энэ нийгмийн талын асуудлуудаа шийдвэрлээд, зөв юманд хөрөнгө оруулаад, ирээдүйд бид ер нь бид нар дандаа буруу юманд хөрөнгө оруулчих юм. Зөв юманд хөрөнгө оруулаад явбал Монгол Улсад боломж их байна. Зөндөө байгаа шүү.

Тэгээд л зарлага талд нь Их Хурлын гишүүдийг баахан хооронд нь муудалцуулчихаад л тэгээд л цаана нь, уул нь орлогоо их олоод, төсвөө тодотгоосой, орлого талыг нь тодотгоосой гэж би хүсэж байна. 34 их наяд биш, 38 их наяд, 40 их наяд төгрөг орлого олох боломж бид нарт байна. Тэрийг олоод тэрийгээ тодотгоод сууж байгаасай 25 оны 2 дугаар улиралд, 3 дугаар улиралд. Энэ бол том амжилт шүү. Хамтарсан Засгийн газрын ер нь хамгийн том зорилт энэ рүү явах ёстой томоохон төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх, орлогоо олоод тэгээд энийгээ ер нь сайжруулах хамтарсан Засгийн газрын гол зорилт байх. Амжилт хүсье. Би тэр Байнгын хорооны дүгнэлттэй холбуулж нэрээ өгсөн байсан. Тийм учраас тэгж үг хэллээ.

Д.Амарбаясгалан: Санал хураалт Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Энэ зарчмын зөрүүтэй санал дээр үг хэлэх юм уу? Чинбүрэн гишүүн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Энэ барилгын магадлах бас их чухал юм. Сая бас энэ төсвийн ажлын хэсэг маш сайн ажиллалаа. Ялангуяа энэ хавдрын асуудлыг бас онцгой анхаарч, энэ дээр санхүүжилтийг нь хуучин барилгын засвар үйлчилгээг бүтэн төсвийг нь тавилаа. Ер нь энэ парламентад хараад байхад энэ 16-20 оны парламент бас хавдар судлалын, хавдрын өвчлөлийг бууруулах чиглэлд маш чухал төсөв баталсан нь Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг хийж чадаж бид ирээдүйн элэгний хорт хавдрын өвчлөлийг, В, С вирусийг бууруулснаараа буулгах боломжийг бүрдүүлсэн том түүхэн гавьяа байгуулсан.

20-24 оны парламент бид бас энэ хууль, эрх зүйн орчинд хорт хавдартай хүмүүсийн эмчилгээг санхүүгийн дарамтгүй эмчилж чаддаг ийм тогтолцоог хийж чадсан бас түүхэн гавьяатай. Мөн элэгний Д вирус эмчлэх чиглэлд 10 тэрбум төгрөг тавьж энэ эмчилгээг Монгол Улсад 20-24 онд бид эхлүүлж чадсан. Мөн 20-24 онд бид Хавдар судлалын эмнэлгийн-II төслийг хэрэгжүүлэх 10 тэрбум төгрөг суулгаж, мөн ажлын зураг төсвийг хийх 3 тэрбумын тендер зарлаж ажил нь явсан. Одоо 24 онд 5 тэрбум төгрөг байгаа. Эрүүл мэндийн сайд энэ дээр анхаарч 24 он дууслаа. Одоо Хавдар-II төслийн үйл ажиллагааг явуулах хэрэгтэй.

Тэгэхлээр та бүхэн сая тогтоолын төсөлд хавдрын эмнэлэг авах чиглэлд өмнөх төсөлд нь 5 жилийн хугацаанд гэж байсан бол одоо тэр жилийг аваад маш шуурхай Хавдар судлалын төвийн ачааллыг 20 хувь бууруулах энэ боломжийг

бүрдүүлсэн тогтоол гаргаж байгаа нь өөрөө бас их түүхэн гавьяа байгаа юм. Тийм учраас энэ маш их зүйтэй боллоо.

Гагцхүү харин Хөгжлийн банканд тэр битүүмжлэгдсэн барилгыг бодит үнээр авах нь их чухал. Тийм учраас энэ магадлах гэдэг энэ тогтоол өөрөө их тийм чухал байгаа юм. Хэрвээ энэ тогтоол дэмжигдвэл бас энэ Хавдар судлалын төвийн өргөтгөлийг авах гэж байгаа энэ шинэ барилгын, энэ барилгын бодит дүнг магадлан шалгаасай, энэ Засгийн газар анхаараасай гэж би бас дэмжиж үг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. ингээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 гишүүн буюу 68.2 хувиар санал дэмжигдлээ.

Саналаа өгч чадаагүй Батсүмбэрэл, Батлут, Ганхуяг, Даваасүрэн, Батжаргал гэсэн гишүүдийг дэмжсэнээр протоколд нэмж тэмдэглэе.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах тогтоолын төслүүдийг батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

11.52 цаг

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг, хөөе Шадар сайд санал хураалт явах гэж байна. 64-өөр санал хураана, гишүүд сууя, Хариуцлагатай байя гэж хэлсэн байх аа. Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа. Санал хураалт 64 гишүүнээр батлагдана.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Нийт 84 гишүүн буюу 76.4 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

85 гишүүн буюу 77.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

85 гишүүн буюу 77.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

4.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

88 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

84 гишүүн буюу 76.4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

7.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

8. “Засгийн газарт чиглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

88 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

9. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

86 гишүүн буюу 78.2 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүд батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийн дараа явуулна.

Дараагийн асуудалд оръё.

11.59 цаг

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн танилцуулна. Индэрт урьж байна

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 12 сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг бэлтгэх асуудлыг хэлэлцлээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөл болон холбогдох хавсралтуудад тусгаж Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан болно.

Төрийн зарим байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдэхээр тооцсон шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг нийт 40.1 тэрбум төгрөгөөр, мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг 3 тэрбум төгрөгөөр, Эрчим хүчний реформын үндэсний хорооны мэдээлэл сурталчилгааны зардлыг 9 тэрбум төгрөгөөр, бүх төсөвт байгууллагын түлш, халаалтын зардлыг 11.5 тэрбум төгрөгөөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг 2 тэрбум төгрөгөөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууралтай тэмцэх сангийн санхүүжилтийг 6.9 тэрбум төгрөгөөр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг 0.7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан, төсвийн нийт урсгал зардлыг 73.2 тэрбум төгрөгөөр бууруулсан болно.

Дээрх зардлын эх үүсвэрээр хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөрт 17 тэрбум төгрөг, тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардал 6.9 тэрбум төгрөг, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 31.4 тэрбум төгрөг, цэцэрлэг 3 ээлжээр хичээллэж байгаа ЕБС-ийн байрны түрээсийн зардалд 10 тэрбум төгрөг, Хавдар Судлалын Үндэсний төвийн барилгын засварт 2.9 тэрбум төгрөг, эрчим хүчний бодлогын шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 5 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсвийн төсөлд тус тус нэмж тусгалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дээрх өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримталсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн...микрофон байхгүй болчихлоо.

Д.Амарбаясгалан: Микрофон нь хаагдчихлаа.

Ц.Даваасүрэн: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслүүдийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт, тооцоог та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн төсвийн төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хамтатган явуулж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан тайлбар хийх, асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

5 гишүүнээр тасаллаа. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Би төсвийн ажлын хэсэгт орж ажилласан гишүүдийн нэг байгаа юм. Тэгээд 2025 оны төсөвт 9 тэрбумаар эрчим хүчтэй холбоотой олон нийт, хэвлэл мэдээллийн зардал гэж тавигдсан байсныг төсвийн ажлын хэсгээс хасуулсан байгаа юм. Тэгээд энэ дээр бас Доржханд сайдаас асууя гэж бодоод байгаа юм. Эрчим хүчний үндэсний хорооны гишүүдэд яагаад энэ талаар мэдэгдэлгүй тавьсан бэ? Энэ Эрчим хүчний үндэсний хороонд 6, надаас гадна 6 гишүүн байгаа. Тэр 6 гишүүн бүгдээрээ ямар ч мэдээлэлгүй байж байхад энэ төсөв тавигдсан байсан. Тэгээд бас нэг зүйл болохоороо энэ Эрчим хүчний үндэсний хороотой холбоотой өөр том төсөв гарсан байгаа юу гэж Сангийн сайдаас бас асууя, Доржханд сайдаас асууя. Яагаад гэхээр энэ дээр миний мэдэхээр ажлын алба байгуулагдаагүй байна гээд, ямар нэгэн байдлаар төсвүүд гараагүй гэж надад мэдээлэлтэй байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар бас юмаа нээлттэй мэддэг дээрээс нь юу болоод байгаа талаар ингээд мэдэхгүй байх боломжгүй болохоор яг чуулганы танхимаас энийг баталгаажуулаад хариуцлагатайгаар бас мэдэгдлүүдээ аваад үлдэх хэрэгтэй байх гэж бодож байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүн өөрөө төсөв захиран зарцуулах эрхгүй, энэ хуулийг тогтоох, дээрээс нь хууль хэрэгжилтийг хянах үндсэн чиг үүргээр ажиллаж байгаа юм. Тэгэхээр энэ үндэсний хороодтой холбоотойгоор ер нь цаашид ямар байдлууд үүсээд явж байгаа юм бэ гэдгийг би бас асуумаар байна.

Тэгэхээр энэ үндэсний хороонд ажиллаж байгаа гишүүдэд бас дараа нь ямар нэгэн асуудлууд үүсэх үү, үгүй юү гэдгийг ч гэсэн бид нар тодорхой болгож явах шаардлагатай гэж бодож байна. Тэгэхээр энэ асуудлыг асууя.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Доржханд, Тогмидын Доржханд хариулт өгье.

Т.Доржханд: Тэгэхлээр маш тодорхой асуулт асууж байна. Маш тодорхой хариулъя.

Нэгдүгээрт, энэ эрчим хүчний шилжилт хийнэ гэдэг энэ шилжилтийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүд тухайлбал, гурван намын бас ингээд төлөөллүүд ороод, бүрэлдэхүүнд нь ороод явж байгаа. Үүний нэг нь тухайлбал манай Цэнгүүн гишүүн байгаа.

Тэгээд би нэг зүйлийг бас ингээд тодорхой хэлмээр байна. Цэнгүүн гишүүний хувьд ямар нэгэн тийм сонирхол байхгүйгээр чин сэтгэлээсээ ажилласан. Нэг.

Хоёрдугаарт, энэ эрчим хүчний шилжилттэй холбоотойгоор их хэмжээний хэвлэл, нийтлэлтэй холбоотой, мэдээлэлтэй холбоотой зардалд тусгагдаад байна гэдэг буруу мэдээлэл явсан. Тухайлбал, 1.2 тэрбум төгрөг энэ онд суучихсан байна. Энийг Цэнгүүн гишүүн өөрөө тараагаад явж байна гэсэн байдлаар мэдээлэл явсан. Энэ худлаа мэдээлэл. Одоо хүртэл тэр мөнгө нь гараагүй байгаа. Эрчим хүчний үндэсний хорооны ажлын алба ердөө байгуулагдаад ердөө л 2 долоо хонож байгаа. Одоо 1 ч төгрөг гараагүй Сангийн яаман дээр ингээд хүлээгдэж байгаа шүү. Маш олон хүмүүс асуугаад байгаа Эрчим хүчний үндэсний хороо үнэ л, үнийн л асуудал хөндлөө. Өөр юу хийсэн юм гээд. Зардал байхгүй юм чинь юу хийх юм бэ? Ажлын алба нь байгуулагдаагүй шүү дээ энэ чинь. Дөнгөж л одоо ингээд явж байгаа.

Одоо ингээд л бид нар реформ хийнэ гэхлээр 3 жил хамгийн багадаа зарцуулах байхгүй юу. Салбарын бүтцийн өөрчлөлт хийнэ, бодлогын бичиг баримтууд хийнэ. Бодлогын бичиг баримтууд байгаа гэсэн мөртөө тэр нь олон улсын байгууллагуудын бичиг баримтуудыг хэлээд байдаг. Шилжилтийн бичиг баримт байхгүй, санхүүжилтийн бичиг баримт байхгүй, маш олон бичиг баримтууд байхгүй байхгүй юу. Ийшийгээ бид нар ингээд зардал тавиад явсан чинь энийг 8 тэрбум төгрөгийг тухайлбал зарлал, сурталчилгаанд өгөх юм байна гэсэн ийм буруу мэдээлэл явчихсан. Энэ бол манай 8, 9 сард нөгөө Сангийн яаманд 10 сард өгсөн бичиг байсан.

Түүн дээр ялт ч байхгүй иргэд олон нийттэй гэдэг ийм бичиг явсан нь үнэн. Энэ хугацаанд 2 сарын хугацаанд бид нар задаргаагаа өөрчлөөд ийм ийм ажлуудыг хийнэ ээ гээд энэ дотор маш олон бичиг цаасны ажил байгаа. Ердөө 500 сая төгрөг нь л хэвлэл, мэдээлэлтэй холбоотой зардал байхгүй юу. Энийг манай

зарим нөхдүүд бас ингээд буруугаар ойлгоод хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мушгиж яриад байгаа. Тийм зүйл огт байхгүй шүү. Тийм зүйл огт байхгүй.

Эрчим хүчний үндэсний хорооноос өнөөдөр 1 ч төгрөгийн зардал гаргаагүй байгаа. Яагаад гэвэл төсөв байхгүй. Ирэх жил дахиад ингээд тавьсан төсвийг маань ингээд танаад хаясан.

Тэгэхдээ бид энэ эрчим хүчний шилжилтийн ард гарна. Өнөөдөр бүтцийн өөрчлөлт хийхийн тулд салбар дээр бас ажиллах шаардлагатай байгаа. Мэдээж энэ л амархан ажил биш. Эсэргүүцэл тулгарч байгаа. Өнөөдөр цахилгааны хязгаарлалттай байгаа. Энэ асуудлыг чинь бид нар шийдэх гэж өнөөдөр реформ хийж байгаа шүү. Цаашаага бид нар энэ нийлүүлэлтийг өсгөх замаар, хөрөнгө оруулалтыг бий болгох замаар, эрчим хүчний тусдаа биеэ даасан байдлыг хийж чадна. 3 жилийн дотор хийж чадна, экспортоо ч бас хийнэ. Үүний төлөө хамтарсан Засгийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Юуны өмнө бас төсвийг нэлээн бас танах шийдвэр байсан хэдий ч гэсэн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ 1 сарын 1-нээсээ бас нэмдэг зарчим дээрээ нэгдсэн бас гишүүддээ талархлаа илэрхийлье.

Зарим салбарынхыг бас төсөв дотор нь зохицуулаад, өшөө илүү энэнээс нэмэх боломжийг нь олоод, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбар дээр би байгаа гэдэг ойлголт авсан. Хуульд байгаа зарим нэг зардлууд ерөөсөө заавал ч үгүй гаргах ёстой. Тухайлбал, тэр хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой, төрөөс хариуцах ёстой төсөвт байгууллагууд аюулгүй байдал нь эрүүл ахуйдаа гаргах ёстой энэ зардлуудыг бас нэлээн хассан, зарим талаар тусгаагүй бас ийм юмнууд яваад байгаа.

Тэгээд энэ тал дээр Сангийн яам маань яг энэ төсөв захирагч нарт хуулийн дагуу гарах ёстой энэ зардлуудаа хэмнэгдэж байгаа зардал болон бусад тэр төсвийнхөө хуульдаа тавиач ээ гэдэг зүйлийг чиглэл өгч, Засгийн газраас чиглэл өгөөд, Сангийн яамнаас чиглэл өгч шийдэж өгөх тал дээр анхаараач.

Тэгэхгүй бол зардал хуваах дотор тэр бүр хүснэгтийг нь аваад хаячихсан, хүмүүс төсвөө мэдүүлэх гэхээр хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг бүүр зардлын ангилал, хүснэгт байхгүй яваад байгаатай холбоотойгоор ингээд олон жил яригдаад яваад байгаа. Тэгээд энэ тал дээр Сангийн яаманд би тусгайлан бас санал хүргүүлсэн. Тэгээд энэ чиглэлээр ирэх онд тухайлбал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гээд яг хууль дээр тодорхой заачихсан ийм зардлуудаа хэрхэн яаж шийдэх тал дээр та бүгдэд бас ажлын хэсэг болон Сангийн яамнаас ямар санал байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би асуултаа асууя. Ирэх жил эдийн засгийн өсөлтийг 8 хувь гэж тооцож байгаа. Инфляцыг 7.2 хувь гэж тооцож байгаа юм. Энэ ер нь хэр бодитой вэ? Одоо ингээд он гараад сая бид нар 11 сарын 15-наас эрчим хүчний үнэ, тарифыг нэмэгдүүлсэн айл өрх, аж ахуйн нэгж ялгавартай байдлаар. Энэ ер

нь суурь үнэ, бараа бүтээгдэхүүний үнэд эхнээсээ ингээд дуу дуугаа авалцаад өргөн хэрэглээ, бараа, бүтээгдэхүүний үнүүд өсөж байгаа. Энэ үнэ, тарифын нэмэгдэл ер нь явж явж айл өрхүүд дээр, тэр дундаа аж ахуйн нэгж, жижиг дунд бизнес эрхлэгч дээр үнэхээр хүнд тусаж байгаа. Хөдөлмөрлөөд хөдөлмөрлөөд, мачийгаад мачийгаад ингээд үндсэндээ өр зээлд ороод түрээсээ төлж чадахгүй, татвараас татварын хооронд, банкны зээлээс зээлийн хооронд л хэцүү байх нь.

Тэгэхээр энэ 7.2 хувийн эдийн засгийн инфляцын өсөлтийг энэ тооцоолол ер нь би ер нь эдийн засгийн инфляцын өсөлт 2 оронтой тоо руу орох байх гэж хараад байх юм. Энэ дээр яаж төлөвлөсөн юм? Тэгсэн хэр нь төсөв тэллээ, данхайлаа, томорлоо гээд байдаг. Тэр хэрээрээ бид нар урсгал зардлаа нэмэгдүүлсэн байна.

Тухайлбал, төсвийн ажлын хэсэг ажиллаад 12, 3 нэр төрлийн байгууллагууд дээр нийтдээ 3000 гаруй төрийн албан хаагчдыг нэмэхээр оруулж ирсэн байсныг ажлын хэсэг ажиллаад 1200-гаар бууруулсан байна. Төсвийг нь орон тоог нь хасаж 100 гаруй тэрбум төгрөгийг нь танасан байна.

Тэгээд нөгөө манай байгууллагууд бас бүтэц, орон тоо, бичиг хэргийн зардал хасчихлаа, таначихлаа гээд яриад байсан чинь үгүй 2024 оны гүйцэтгэл дээрээ 50 хувиар нэмэгдүүлж байгаа юм байна лээ шүү бүтэц, орон тоонуудаа энэ орон тоо хасагдлаа гэж яриад байгаа байгууллагууд. Тэгэхээр энэ бас л төсөв яаж их данхайсан, яаж их нэмэгдсэнийг шууд харуулах, илтгэх тоо байхгүй юу.

Тэгэхээр ингээд 1 жилийн дотор төрийн алба ингээд 3, 4 мянгаар нэмэгдэнэ гэж юу байх вэ дээ. Энэ чинь л ард иргэдийн нөгөө эсэргүүцээд байгаа хүнд зориулсан орон тоо юмнуудыг нэмээд байгаа, төсөв нэмэхийн хэрээр л орон тоог нэмээд байгаа гэдгийг харуулаад байгаа юм.

Тийм учраас үнэхээр бас 1200 орон тоо бас нэмнэ гэдэг бас л өндөр тоо байна. Энэ дээр ажлын хэсэг яаж ажилласан, үнэхээр энэ 1200 оронтой байх ёстой юм байна гэж үзсэн үү, үгүй юү? Өшөө бууруулах бололцоо, боломж байгаа юу, эсвэл бүүр үнэхээр хуулиудаараа хэрэгжүүлэх нэмэх ёстой гэж үзэж байгаа юу? Энх-Амгалан сайдаас 1 асуулт асууя. Бид нар хавар хууль батлахдаа хороонууд дээр, сумууд дээр гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны орон тоог шинээр бий болгосон. Энэ орон тоо ирэх жилээс нэмэгдэж байгаа юу, нэмэгдэхгүй байгаа юу? Бас энд хасалтад ороод хасагдчихав уу?

Мөн Биеийн тамир спортын тухай хууль дээр бид нар өөрчлөлт оруулж бас хороонууд дээр, сумууд дээр биеийн тамирын арга зүйчийн орон тоог бас нэмснийг санаж байна энэ хуулиар. Энэ орон тоо бас яаж нэмэгдэж байгаа вэ, нэмэгдэж байгаа юу бас хасагдаад явчхаж байгаа юу гэх мэтчилэн нөгөө хавар хуулиудаар хуулийн хүрээнд нэмчихсэн орон тоонуудаа буцаагаад төсөв батлахдаа хасаад явчихаар энэ хуулиуддаа өөрчлөлтөө оруулах юм уу, хуулиа зөрчөөд явчхаж байгаа юм уу? Ийм асуудлууд үүсээд байна. Энэ дээр хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн Эрдэнэбат гишүүний асуултад тодруулж, мөн Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Г.Тэмүүлэн: Тэгье. Эхлээд Сандаг-Очир гишүүний асуултад бас хариулъя.

Тэгэхээр үндсэндээ яах вэ, бид бүхний хувьд энэ удаагийн төсөв өөрөө бас энэ үрэлгэн төсвүүдийг бас үр ашигтай байлгах, дээрээс нь тодорхой хэмжээний хэмнэж болох зардлуудыг хэмнэх чиглэлээр бол ажилласан. Энэ хүрээндээ бид нар магадгүй тодорхой Засгийн газраас орж ирсэн байсан 3700 орчим шинэ орон тоог бол хязгаарлах, 1 жилийн хэмжээнд тэвчиж болох энэ орон тооны хязгаарыг бас хэрэгцээтэй газар нь хязгаарлаж, хэрэгцээтэй газар нь нэмэх ёстой гэсэн энэ байр сууриас хандсан.

Нэг бүрчлэн үзээд энэ энэ дээрээс хэрэгцээгүй тодорхой энэ жилдээ тэвчиж болох байгууллагууд дээр 100 хувь нэмэхийг нь, шинэ орон тоог нь 100 хувь нэмэгдүүлэхийг нь хязгаарлаад, тодорхой хэрэгцээтэй байгаа шаардлагуудтай газар дээр нь 50 хувиар нэмэгдүүлэх, түүний цалингийнх нь зардлыг нь бол тусад нь тавьж өгсөн байгаа гэдгийг бас хэлэх байна.

Тэгээд бид нар нэг бүрчлэн энэ тухайн байгууллагуудтай саналуудыг нь авч, ярилцаж, хөөрч тодорхой судалгаануудыг нь үзсэний үндсэн дээр гэсэн.

Саяын таны асуусан эдийн засагтай холбоотойгоор, ер нь энэ эдийн засаг болоод инфляцын асуудал маань ирэх онд ер нь хүлээлт нь ямар байгаа юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ, эдийн засгийн нөхцөл байдал, төлөв байдал бид нар бас, гадаад нөхцөл байдал бас нэлээн эрсдэлтэй байгаа. Тодорхой бус байдлууд бас байна. Энэ үндсэн дээр Монголбанктай бид нар судалж үзээд ерөнхийдөө ажлын хэсэг энэ тал дээр бас Монголбанкнаас мэдээлэл авсан. Эдийн засгийн өсөлт 3 дугаар улиралд хүлээлтээс доогуур байна гэж байгаа юм. Хүлээлтээс.

Тэгэхээр одоо энэ төсөв дээр орж ирсэн эдийн засгийн өсөлт бол магадгүй Монголбанкнаас бид бүхэнд өгсөн юугаар бол ойролцоогоор одоо энэ төсөв маань инфляц, эдийн засгийн өсөлт, өсөлтөд бол 1 хувиар нөлөөлөх ийм нөлөөлөл байна. Импортод 500 сая ам.доллар нөлөөл бол байна гэж байгаа юм.

Гэхдээ угаасаа төсөв 7.2 дээр нэмэх нь дээшээ, доошоо бас хязгааруудаа зааж орж ирсэн. Инфляцын хувьд инфляцын дарамт 2-оос, 2, 3 дугаар улирлаас нэмэгдэх, том нөлөө гарах тийм эрсдэл бол байна гэж харж байгаа. Үүнд гол нөлөөлөгч хүчин зүйл нь цалингийн өсөлт, цахилгаан, дулаан, үнийн өсөлт, өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээний нэмэгдэл буюу импорт өдөөж байгаа энэ төсвийн зардалтай холбоотой асуудлууд, мөн дээрээс нь бас энэ оноос эхлээд энэ хүнсний бус хэрэглээ нэмэгдээд байгаа юм. Автомашин болон үл хөдлөх хөрөнгийн асуудлууд.

Тэгэхээр эдгээр асуудлууд маань бас инфляц дээр энэ төсвийн нөлөөлөл маань бас 1 хувиар нөлөөлөх нөлөөлөл бол байна гэсэн мэдээллийг өгсөн. Энэ бол нэг талдаа одоо бол шинэ өргөн баригдсан төсвийн хүрээнд бид нар хэрэв юу гэдэг юм өмнөх төсөв маань юу гэдэг юм явсан болбол магадгүй 2.4 их наядар нөлөөлсөн бол инфляцад доод тал нь 1.5 хувиар нөлөөлөх нөлөөлөл бол бас орж ирнэ гэсэн ийм тооцооллыг, ханш дээр бас тодорхой хэмжээнд 150-175 төг.../минут дуусав./

Х.Булгантуяа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Сандаг-Очир гишүүн ээ энэ 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Идэрбат гишүүн та нарын батлуулсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт ирэх онд бүрэн хэрэгжиж эхэлнэ. Ингээд саяын Ерөнхийлөгчийн хориг тавихаас өмнөх төсөв дээр бол нэгд хүүхэд хамгааллын зардлыг бид нар 23 тэрбум төгрөгөөр батлуулсан байсан.

Тэгээд сая тодорхой Ерөнхийлөгчийн хоригийн дараа бол 3 тэрбумаар хасагдаж, 20 тэрбум болсон байгаа. Гэхдээ 20 тэрбум гэдэг мөнгө бол 24 оны гүйцэтгэлтэй харьцуулахад бол бас 1 дахин нэмэгдэж байгаа. 24 оны гүйцэтгэлээр бид нар 11 тэрбум төгрөгийн зардалтай гарч байгаа юм байна лээ.

Тэгэхээр 24.8 тэрбум гэдэг бол бас нэлээн ирэх жил хүүхэд хамгааллын салбарт нэлээн ахиц гарсан. Яг таны асууж байгаа сум, хороод дээр ажиллах нийгмийн ажилтнуудын зардлууд цалин, нийгмийн даатгалын шимтгэлүүд нь орсон ийм төсөв байгаа.

Х.Булгантуяа: Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр бид улсын төсвөө батлах гээд сууж байна. Нэг онцлог нь энэ танхимд сууж байгаа 81 гишүүн улсын төсвийг анх удаа батлах гэж байгаа юм. Батлах батлахдаа парламентын 34 жилийн түүхэнд анх удаагаа төсвийг дахин батлах ийм үйл явдал болж байна. Нэг төсвөө хоёр баталсан ийм түүхэн хүмүүс болж байна гэсэн үг нэг талаасаа.

Нөгөө талаасаа энэ төсвийн хэлэлцүүлгийг харахаар ерөөсөө 2 туйл руу л явлаа. Эхний удаа ерөөсөө бүх зардлыг ханая, таная. Энэ чиглэл рүүгээ явж савласан. Дараагийн энэ удаагийн хэлэлцүүлгийг ингээд харахаар ерөөсөө энэ зардлуудыг хасахгүй байя, нутагтаа, салбартаа одоо хачин их хайртай хүмүүс гарч ирсэн. Ингээд төсвийн зардлыг нэмэгдүүлэе гэдэг ийм тал руу маш их хэлэлцүүлэг өрнөлөө. Ийм хэлэлцүүлгүүд боллоо.

Тэгэхээр энэ жилийн төсөв ер нь юу болов оо гэдгээ хэдүүлээ эргээд харъя гэж бодож байгаа юм. Засгийн газраас бүсчилсэн хөгжлийг дэмжье, аймаг, орон нутгийн жижиг төсвүүдийгээ хасаад бүсчилсэн хөгжлөө дэмжээд улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах томоохон төслүүдээ санхүүжүүлэх ийм төсвийг өргөн барьсан. Үүнийг нь Улсын Их Хурал дэмжээд баталсан. Энэ батлах явцад, эцсийн хэлэлцүүлэг хийх үед тодорхой нэр бүхий гишүүд шаар үлдээгээд, шаардлага тавиад гараад ирсэн. 3.6 их наядаар зардлыг танах, төсвийг буцаах ийм шаардлага тавиад гараад ирсэн. Ингээд эрх зүйн хувьд буцаах боломжгүй учраас эцсийн хэлэлцүүлэг хийгээд баталсан. Гэхдээ төсвийн тодотгол хийх тогтоолыг бас хамтад нь баталсан.

Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд хориг тавьсан. Хориг тавьсан үндэслэлүүдийн нэг нь бол 12 дугаар сард төсвийн жил эхлэхээс өмнө тавьж байгаа тодотгол хийх нь эрх зүйн хувьд бас маргаан гарч магадгүй учраас энэ хоригийн хүрээндээ бас энэ асуудлаа шийдвэрлэх нь зүйтэй байна гэсэн ийм үндэслэл, ийм агуулга бас тавьсан гэж бас харж байгаа юм. Ийм ч учраас Улсын Их Хурал хоригийг хүлээж аваад Засгийн газарт буцаасан. Засгийн газар төсвөө өргөн, дахин өргөн бариад бид хэлэлцээд батлах гэж байна.

Засгийн газраас 2.4 их наядыг танасан алдагдалгүй ийм төсвийг өргөн барьсан. Үүнийг нь бид нар өнөөдөр ингээд хэлэлцээд явж байна. Ингээд алдагдалгүй төсөв батална гэдэг ер нь талаас нь, эерэг талаас нь бас харж болно. Төсвийн тэнцлийг сайжруулах, тодорхой зардлуудыг хасах, инфляцын дарамтыг багасгах гэдэг юм уу, төсөвт 1 удаа тохируулга хийх гэдэг талаас нь, эерэг талаас нь бас харж болно.

Гэхдээ олон бас сөрөг талууд байгаа гэдгийг бас та бүгд маань хараарай. Гишүүдийг ингээд харж байхад алдагдалгүй төсөв гэхээсээ илүү үр ашигтай, бага алдагдалтай төсөв батлах тал руугаа явбал яасан юм бэ гэсэн саналыг их олон гишүүд гаргаж байсныг та бүхэн маань бас харсан байх гэж би бодож байгаа юм.

Ер нь алдагдалгүй төсөв баталдаг дэлхий дээр 3 улс байдаг юм байна лээ. Манайх одоо 4 дэх нь болж байгаа. Ийм тал руу явж байна. Бид энэ алдагдалгүй төсөв батлаад ингээд явахаар л нэг л юм байгаа юм. Шууд эдийн засгаа болгох том хөрөнгө оруулалтууд байхгүй, жижиг хөрөнгө оруулалтууд ч байхгүй, сум, орон нутагт сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт ч тавигдахгүй байгаа юм.

Тэгээд л нэг талаасаа орлогын тодорхой эх үүсвэр байхгүй, орлогоо нэмэгдүүлэхгүй, тэгээд орлого, зардлаа тэнцүүлээд л ингээд л нэг дороо л байгаад байх энэ зам руу бид явлаа шүү. 4 жил энэ замаар явах энэ юм руу яваад байгаа юм. Ер нь төсөв дотор сул зардал гэж ер нь байдаггүй юм. Төсвийн хэмнэлтийн хууль гээд их КОВИД-ын үед гарсан их том хууль байгаа. Үнэхээр чанга хууль. Энэ хуулийн хүрээнд ерөөсөө сул зардал гэж байхгүй. Энэ зардал болгоны ард бол Засгийн газрын үйл ажиллагаа, яам, агентлаг, аймаг, сумдын хэвийн үйл ажиллагаа явуулах ийм зардлууд л байгаа ер нь бол.

Тэгэхээр үүний тодорхой хэсгийг нь 10-100 хувь хасаж байна. 50 хувь, 100 хувь хасчаж байгаа. Автоматаар хасчаж байгаа. Ингэхээр үүний цаана тодорхой үйл ажиллагаа санхүүжилтгүй байна, хийх ёстой ажлууд нь хийгдэхгүй үлдэнэ гэсэн энэ агуулга руу бид бас явж байгаа гэдгийг бас та нар маань анхаараарай.

Ирэх онд төлөвлөж байсан олон том хөрөнгө оруулалтууд хийгдэхгүй нь. Том хөрөнгө оруулалтууд бүгд хийгдэхгүй. Тэрний дотор 8 авто зам байгаа. 780 км 8 авто зам орон нутгийн боомттой холбох том замууд маань бас хийгдэхгүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын энэ ашиглалтыг багасгасантай холбогдуулаад цэвэрлэх байгууламж, нөгөө газрын тосны үйлдвэрийн тодорхой санхүүжилт ч гэсэн хасагдаж, хумигдаж байна. Энэ болгон ингээд үзэхээр төсөвт хамгийн их таналт хийсэн ийм төсвийг та бид нар баталж байна. Ингэхээр энд Их Хурлын гишүүдэд бас хариуцлага гарна шүү гэдгийг хэлэх гэж байгаа юм. Энэ бол нь нэгэнт ингээд төсвөө ингээд таначихсан, хумьчихсан, эдийн засгаа хумьчихсан тохиолдолд нөгөө Засгийн газраас оруулж ирж байгаа ураныхаа төслийг хил холболтынхоо төслүүдийг дэмжиж байж бас эдийн засгаа өсгөнө, улс орныхоо хөгжлийг авч явах энэ боломжууд чинь бүрдэнэ шүү гэдгийг бас Их Хурлын гишүүд маань анхаараасай гэж би бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Л.Мөнхбаатар: Тэгэхээр энэ нөхцөл байдлаа бид бас анхаарч үзэхгүй бол яг л энэ нөхцөл байдалтайгаа 4 жил болох нь. Ингээд эцэст нь хэлэхэд энэ улс

төрчид маань бас учраа мэдэж улс төрөө хийхгүй бол энэ улс орныхоо хөгжлийг хязгаарласан ийм нөхцөл байдал руу хөгжлийг хязгаарласан ийм нөхцөл байдал руу бас орж байна. Төрийн үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулсан ийм нөхцөл байдал руу бас явж байгаа шүү гэдгийг бас гишүүд та нар маань бас анхаараарай.

Ер нь улс орны бодлого улс төрчдийн лайк, шэйрний өмнө бас өвдөг сөгдөөд байж болохгүй. Тийм учраас улс орныхоо хөгжлийн төлөө энэ төсөв гэдэг өөрөө хөгжлийн бодлого түлхүүр нь байдаг. Үүнийгээ хаана хаана анхаараарай гэдгийг бас та бүгддээ хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд үг хэлнэ, асуулт асууна.

О.Алтангэрэл: Та бүгдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Хэдүүлээ ч бас төсвөө хэлэлцэж, ярилцах гэж бас л их юм боллоо доо. Хууль сахиулах байгууллагуудын хувьд энэ жил шинээр нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн орон тоог ажлын хэсгээс 100 хувь хасаж бас нэлээн сандаргалаа. Тэр дунд ер нь энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн орон тоог эд нар ер нь нэмэх ямар хэрэгтэй юм. Улам тэлээд байна гэдэг ийм гишүүн ч гарсанд харамсаж байгаа.

Өнөөдөр энэ нийгмийг амар тайван байлгах гэж өдөр, шөнөгүй ажиллаж байгаа энэ хууль сахиулах байгууллагынхандаа анхаарал хандуулаач ээ гэж хүссэний дагуу ажлын хэсэг маань нэмэгдэж байгаа орон тоог 50 хувиар нэмэгдүүлж, Төсвийн байнгын хороо дэмжсэнд талархлаа илэрхийлье.

Мөн 20 хувь буюу энэ 20 хувийн нэмэгдэж байгаа орон тоотой дүйцэхүйц хэмжээний хөрөнгө оруулалтыг ирэх жил цагдаагийн байгууллагын энхийг сахиулах үйл ажиллагааны тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт байдлаар оруулна. Энэ асуудлыг шийдвэрлэнэ гэж Сангийн сайд маань ажлын хэсэг, Төсвийн байнгын хороон дээр амласныг энд албан ёсоор протоколд хэлж тэмдэглүүлье.

Мөн энэ хууль сахиулах байгууллагынхаа хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд онцгой анхаарал тавьж, санаа тавьж ажилласан Хууль зүйн байнгын хорооны дарга, Цогтбаатар дарга, Сайнзориг гишүүн, Баасанжаргал гишүүн, Эрдэнэболд гишүүндээ бас Хууль зүй, дотоод хэргийн салбарын албан хаагчдын өмнөөс талархал илэрхийлье.

Гэхдээ өнөөдөр бас 5000 гаруй яг батлагдсан нормоороо цагдаагийн албан хаагч дутуу байгаа. Бусад хууль сахиулах байгууллагын 2000 гаран албан хаагчийн орон тоо дутуу байгаа гэдгийг ирэх жилийн төсвийн үеэр дахиж ярина. Тангад улс мөхөөгүй гэдэг шиг хууль сахиулах байгууллагын орон тоо бүрэн бүрдээгүй шүү гэдгээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ сонорт хүргэж байна.

Асуулт бас байна. Энэ Сангийн яамныхнаас асууя. Энэ Архидан согтуурахтай тэмцэх сангаас төсөв, мөнгө танана гэж яриад байх юм. Энэ өөрөө хуультай. Төрөөс 1 ч төгрөг ордоггүй сан байхгүй юу. Архи үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүд шил архи тутмаасаа 80 төгрөг өгөөд, түүгээр нь сан бүрдээд ийм ийм зарцуулалтаар бүр тов тодорхой, манай энэ Сайнзориг гишүүн Хууль зүйн

яаман дотор байхад бас санаачилж нэлээн идэвхтэй байж батлуулсан хууль. Үгүй ээ тэгээд ийм өөр зориулалттай хуулийн мөнгийг аваад бид нар өөр юм руу хийнэ гэж энэ чинь хууль зөрчинө шүү дээ. Энэ дээр манай Сангийн яамныхны бодол юу юм бол гэсэн асуулт байгаа юм.

Төгсгөлд нь хэлэхэд бас ажлын хэсэг дээр ярьсан Төсвийн байнгын хороон дээрээс асуудлыг гишүүдийнхээ сонорт хүргэе. Орон тоог бас гүйцэд нэмээгүйгээс шалтгаалан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар ирэх оны 1 сарын 1-нээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжиж ирэх ёстой байсан баривчлах байрны орон тоо тусгагдаагүй тул хуулийн хэрэгжилтийг 1 жилээр хойшлуулах ийм хуулийн төслийг өргөн барина. Та бүхэн маань дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд, Сангийн яамнаас хариулт хийх үү архидан согтуурахтай тэмцэх? Зардлыг чинь бас сая ажлын хэсэг дээр таначихсан байсан уу? Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон Санжаадорж дарга хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Төсвийн бодлого төлөвлөлтийн газар Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Архидан согтуурахтай дэмжих сан бол өөрөө хуулиараа согтууруулах ундаа үйлдвэрлэж байгаа компаниудаас литр тутамд нь тодорхой тариф тавиад ингээд орлого орж ирдэг байгаа.

Нөгөө талдаа энэ сан бол бас зарцуулах чиглэл нь тодорхой байгаад байгаа. Тэгэхлээр энэ сангийн зардал буурснаараа юу болох вэ гэхлээр орлого нь ордоороо орно, нөгөө талдаа зарцуулалт нь байхгүй болчихно гэсэн үг.

Нөгөө талдаа энэ хэмжээгээр зарлага буураад нөгөө юундаа зарцуулна гэхлээр бас энэ орлогынх нь орж ирж байгаа орлогыг зарцуулах зорилготойгоо тийм зөрчилдөх асуудал гарах болов уу гэж бодож байна. Тэгэхдээ энэ саяын санал ажлын хэсэг дээр гарсан санал байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд тайлбар хийж, асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай Төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.20 цаг

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг явуулна.

Төсвийн байнгын хороо төсвийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсож зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг бас төгсгөлд нь явуулна.

Материалаа авъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

64 гишүүнээр санал хураалт дэмжигдэх ёстой. Гишүүд танхимдаа орж ирье. Санал хураалт.

71 гишүүн буюу 64.5 хувиар санал дэмжигдлээ.

Бүртгэлд орсон, танхимд байхгүй байгаа гишүүдийг орж ирж санал хураалтад оролцохыг мэдээлье Тамгын газраас.

2 дугаар зүйл.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай Төсвийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санал хураалт.

76 гишүүн буюу 69.1 хувиар санал дэмжигдлээ.

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлогыг төвлөрүүлнэ:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар 185 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 185 сая.

Монгол Улсын Их Хурлын дарга 100 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 100 сая.

Монгол Улсын Ерөнхий сайд 106 тэрбум 372.5 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 101 тэрбум 600 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 4 тэрбум 772.5 сая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 510 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 510 сая.

Монгол Улсын Ерөнхий аудитор 831.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 831.3 сая.

Төрийн албаны зөвлөлийн дарга 200 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 200 сая.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга 4 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 4 тэрбум.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 2 тэрбум 388.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 тэрбум 388.3 сая.

Монгол Улсын Шадар сайд 20 тэрбум 954.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 20 тэрбум 954.3 сая.

Монгол Улсын Шадар сайд 115.9 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 115.9 сая.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 300 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 300 сая.

Гадаад харилцааны сайд 16 тэрбум 100 сая, Дипломат төлөөлөгчийн газрууд 13 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 3 тэрбум 100 сая.

Сангийн сайд 21 их наяд 278 тэрбум 121.4 сая, Татварын ерөнхий газар 12 их наяд 731 тэрбум 9.6 сая, үүнээс Тогтворжуулалтын санд 608 тэрбум 889.9 сая, Гаалийн ерөнхий газар 7 их наяд 872 тэрбум 540 сая, Сангийн яам 248 тэрбум 209.1 сая, Гадаад тусламжийн орлогоос санхүүжих 417 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 9 тэрбум 362.6 сая.

Хууль зүй, дотоод хэргийн сайд 81 тэрбум 156.8 сая, Улсын бүртгэлийн ерөнхий газар 45 тэрбум 730 сая, Цагдаагийн ерөнхий газар 2 тэрбум 370 сая, Шүүх шинжилгээний ерөнхий газар 300 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого 1 тэрбум 52.5 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 31 тэрбум 704.4 сая.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 412 тэрбум 848.1 сая, Ашигт малтмал, газрын тосны газар 407 тэрбум 301.1 сая, Үндэсний геологийн алба 120 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 5 тэрбум 427 сая,

Батлан хамгаалахын сайд 43 тэрбум 187.2 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 43 тэрбум 187.2 сая.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 2 тэрбум 226.9 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 тэрбум 226.9 сая, Боловсролын сайд 5 тэрбум 534.8 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 5 тэрбум 534.8 сая.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 304 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 304 сая.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 69 тэрбум 153.9 сая, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар 1 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого 3 тэрбум 35.1 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 65 тэрбум 118.8 сая.

Зам тээврийн сайд 110 тэрбум 656 сая, Иргэний нисэхийн ерөнхий газар 80 тэрбум, Зам, тээврийн яам 300 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 30 тэрбум 356 сая.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 49 тэрбум 173.6 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 49 тэрбум 173.6 сая.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 8 тэрбум 663.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 8 тэрбум 663.3 сая.

Эрүүл мэндийн сайд 7 тэрбум 945.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 7 тэрбум 945.3 сая.

Санал хураалт.

81 гишүүн буюу 73.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 22 их наяд 837 тэрбум 920.9 сая төгрөг байна.

Санал хураалт.

80 гишүүн буюу 72.7 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх үндсэн төлбөрийг төлнө:

Сангийн сайд 387 тэрбум 133.9 сая.

Хууль зүй, дотоод хэргийн сайд 20 тэрбум 600.7 сая.

Боловсролын сайд 30 тэрбум.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 62 тэрбум 310.3 сая.

Санал хураалт.

82 гишүүн буюу 74.5 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйл.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсвийг зарцуулна:

6.1.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга 37 тэрбум 603 сая, Урсгал зардал 36 тэрбум 603 сая, Хөрөнгийн зардал 1 тэрбум.

Монгол Улсын Их Хурлын дарга 170 тэрбум 302.4 сая, Урсгал зардал 161 тэрбум 742.4 сая, Хөрөнгийн зардал 8 тэрбум 560 сая.

Монгол Улсын Ерөнхий сайд 626 тэрбум 974.8 сая, Урсгал зардал 367 тэрбум 312.1 сая, Хөрөнгийн зардал 259 тэрбум 662.7 сая.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга 5 тэрбум 488.7 сая, Урсгал зардал 5 тэрбум 488.7 сая.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч 31 тэрбум 861.6 сая, Урсгал зардал 27 тэрбум 233.4 сая, Хөрөнгийн зардал 4 тэрбум 628.2 сая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 329 тэрбум 796.4 сая, Урсгал зардал 266 тэрбум 811.9 сая, Хөрөнгийн зардал 62 тэрбум 984.5 сая.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга 14 тэрбум 896.9 сая, Урсгал зардал 12 тэрбум 184.9 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум 712 сая.

Улсын ерөнхий прокурор 157 тэрбум 568.5 сая, Урсгал зардал 127 тэрбум 719.4 сая, Хөрөнгийн зардал 29 тэрбум 849.1 сая.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга 22 тэрбум 569.7 сая, Урсгал зардал 22 тэрбум 569.7 сая.

Монгол Улсын Ерөнхий аудитор 54 тэрбум 388.4 сая, Урсгал зардал 53 тэрбум 209.6 сая, Хөрөнгийн зардал 1 тэрбум 178.8 сая.

Авлигатай тэмцэх газрын дарга 56 тэрбум 946 сая, Урсгал зардал 54 тэрбум 585.1 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум 360.9 сая.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга 21 тэрбум 703.7 сая, Урсгал зардал 21 тэрбум 453.7 сая, Хөрөнгийн зардал 250 сая.

Төрийн албаны зөвлөлийн дарга 19 тэрбум 420.4 сая, Урсгал зардал 19 тэрбум 420.4 сая.

Үндэсний статистикийн хорооны дарга 34 тэрбум 392.7 сая, Урсгал зардал 32 тэрбум 392.7 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга 15 тэрбум 750.3 сая, Урсгал зардал 15 тэрбум 750.3 сая.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга 1 тэрбум 310.2 сая, Урсгал зардал 1 тэрбум 310.2 сая.

Шүүхийн сахилгын хорооны дарга 6 тэрбум 171.9 сая, Урсгал зардал 5 тэрбум 871.9 сая, Хөрөнгийн зардал 300 сая.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд 276 тэрбум 31.2 сая, Урсгал зардал 117 тэрбум 454.2 сая, Хөрөнгийн зардал 158 тэрбум 577 сая.

Монгол Улсын Шадар сайд 388 тэрбум 505.5 сая, Урсгал зардал 324 тэрбум 292.9 сая, Хөрөнгийн зардал 64 тэрбум 212.6 сая.

Монгол Улсын Шадар сайд 8 тэрбум 46.9 сая, Урсгал зардал 8 тэрбум 46.9 сая.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 141 тэрбум 257.7 сая, Урсгал зардал 117 тэрбум 27.1 сая, Хөрөнгийн зардал 24 тэрбум 230.6 сая.

Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга 19 тэрбум 337 сая, Урсгал зардал 16 тэрбум 928.9 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум 408.1 сая.

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга 13 тэрбум 537 сая, Урсгал зардал 5 тэрбум 438.5 сая, Хөрөнгийн зардал 8 тэрбум 98.5 сая.

Монгол Улсын сайд, 20 минутын Үндэсний хорооны дарга 20 тэрбум 51.7 сая, Урсгал зардал 4 тэрбум 380.2 сая, Хөрөнгийн зардал 15 тэрбум 671.5 сая.

Гадаад харилцааны сайд 262 тэрбум 290.7 сая, Урсгал зардал 251 тэрбум 40.3 сая, Хөрөнгийн зардал 11 тэрбум 250.4 сая.

Сангийн сайд 4 их наяд 877 тэрбум 188.4 сая, Урсгал зардал 2 их наяд 791 тэрбум 510.7 сая. Үүнээс зээлийн хүүгийн төлбөрт 1 их наяд 297 тэрбум 70.7 сая, Хөрөнгийн зардал 126 тэрбум 249.3 сая. Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал 1 их наяд 959 тэрбум 428.4 сая.

Хууль зүй, дотоод хэргийн сайд 1 их наяд 725 тэрбум 373.2 сая, Урсгал зардал 1 их наяд 616 тэрбум 821.3 сая, Хөрөнгийн зардал 108 тэрбум 551.9 сая.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 48 тэрбум 952.1 сая, Урсгал зардал 27 тэрбум 968.1 сая, Хөрөнгийн зардал 20 тэрбум 984 сая.

Батлан хамгаалахын сайд 819 тэрбум 580.7 сая, Урсгал зардал 744 тэрбум 176.8 сая, Хөрөнгийн зардал 75 тэрбум 403.9 сая.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 308 тэрбум 571.6 сая, Урсгал зардал 227 тэрбум 741.8 сая, Хөрөнгийн зардал 80 тэрбум 829.8 сая.

Боловсролын сайд 4 их наяд 466 тэрбум 80.8 сая, Урсгал зардал 3 их наяд 993 тэрбум 403 сая, Хөрөнгийн зардал 472 тэрбум 677.8 сая.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 4 их наяд 495 тэрбум 704.2 сая, Урсгал зардал 4 их наяд 443 тэрбум 461.9 сая, Хөрөнгийн зардал 52 тэрбум 242.3 сая.

Зам, тээврийн сайд 1 их наяд 91 тэрбум 171.8 сая, Урсгал зардал 24 тэрбум 362.8 сая, Хөрөнгийн зардал 1 их наяд 66 тэрбум 809 сая.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 525 тэрбум 351.8 сая, Урсгал зардал 380 тэрбум 106.1 сая, Хөрөнгийн зардал 145 тэрбум 245.7 сая.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 424 тэрбум 32.5 сая, Урсгал зардал 69 тэрбум 935.2 сая, Хөрөнгийн зардал 354 тэрбум 97.3 сая.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 723 тэрбум 2.5 сая, Урсгал зардал 664 тэрбум 422 сая, Хөрөнгийн зардал 58 тэрбум 580.5 сая.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 118 тэрбум 430.3 сая, Урсгал зардал 82 тэрбум 685.2 сая, Хөрөнгийн зардал 35 тэрбум 745.1 сая.

Эрчим хүчний сайд 298 тэрбум 411 сая, Урсгал зардал 102 тэрбум 217.8 сая, Хөрөнгийн зардал 196 тэрбум 193.2 сая.

Эрүүл мэндийн сайд 1 их наяд 847 тэрбум 422.9 сая, Урсгал зардал 1 их наяд 654 тэрбум 327.4 сая, Хөрөнгийн зардал 193 тэрбум 95.6 сая.

6.2.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилтийг олгоно:

Сангийн сайд 41 тэрбум 165.2 сая.

Боловсролын сайд 27 тэрбум 932.7 сая.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 89 тэрбум 831.9 сая.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 4 тэрбум 500 сая.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 40 тэрбум 985.7 сая.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 24 их наяд 209 тэрбум 847.5 сая төгрөг байна.

Санал хураалт.

85 гишүүн буюу 77.3 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ барилга байгууламжийг 3 их наяд 124 тэрбум 66 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

9 дүгээр зүйл. “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд 107 тэрбум 132.1 сая төгрөгийн эргэн төлөлтийг хийнэ.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

10 дугаар зүйл. Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 1 их наяд 596 тэрбум 178.2 сая төгрөг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд 608 тэрбум 889.9 сая төгрөг хуримтлуулна.

Санал хураалт.

86 гишүүн буюу 78.2 хувиар санал дэмжигдлээ.

11 дүгээр зүйл. 2025 оны төсвийн жилд Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээг доор дурдсанаар баталсугай:

11.1. Өрийн удирдлагын тухай хуулийн³ 12.1.2, 12.1.3-т заасан зориулалтаар хийх дотоод зээлийн дээд хэмжээ 300 тэрбум төгрөг хүртэл;

11.2. Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 1 их наяд 542 тэрбум 428.3 сая төгрөг хүртэл;

Санал хураалт.

84 гишүүн буюу 76.4 хувиар дэмжигдлээ.

12 дугаар зүйл.Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнүүдээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1 их наяд 669 тэрбум 739.8 сая төгрөг байна.

Санал хураалт.

88 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

13.Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ 2025 оны төсвийн жилд 3 их наяд 500 тэрбум төгрөг байна.

Санал хураалт.

89 гишүүн буюу 80.9 хувиар санал дэмжигдлээ.

14.Засгийн газрын төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.4-т заасан зориулалтаар Засгийн газрын өрийн удирдлагын 2023-25 оны стратегийн бичиг баримт⁴ нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Санал хураалт.

89 гишүүн буюу 80.9 хувиар санал дэмжигдлээ.

3 дугаар бүлэг Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

15 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно:

Архангай аймаг 46 тэрбум 462.2 сая төгрөг.

Баян-Өлгий аймаг 29 тэрбум 659.7 сая төгрөг.

Баянхонгор аймаг 37 тэрбум 765.3 сая төгрөг.

Булган аймаг 17 тэрбум 895.3 сая төгрөг.

Говь-Алтай аймаг 29 тэрбум 685.2 сая төгрөг.

Дундговь аймаг 19 тэрбум 308.7 сая төгрөг.

Завхан аймаг 47 тэрбум 684.4 сая төгрөг.

Өвөрхангай аймаг 36 тэрбум 362 сая төгрөг.

Сүхбаатар аймаг 22 тэрбум 417.2 сая төгрөг.

Төв аймаг 2 тэрбум 154 сая төгрөг.

Увс аймаг 39 тэрбум 573 сая төгрөг.

Ховд аймаг 14 тэрбум 41.6 сая төгрөг.

Хөвсгөл аймаг 52 тэрбум 173.4 сая төгрөг.

Хэнтий аймаг 40 тэрбум 849.4 сая төгрөг.

Говьсүмбэр аймаг 9 тэрбум 282 сая төгрөг.

Нийт дүнгээрээ 445 тэрбум 313.4 сая төгрөг.

Санал хураалт.

89 гишүүн буюу 80.9 хувиар санал дэмжигдлээ.

16 дугаар зүйл. 2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт дор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Дорноговь аймаг 11 тэрбум 755.7 сая.

Дорнод аймаг 448 сая.

Өмнөговь аймаг 1 их наяд 769 тэрбум 143.3 сая.

Сэлэнгэ аймаг 2 тэрбум 187.4 сая.

Дархан-Уул аймаг 2 тэрбум 981.1 сая.

Орхон аймаг 145 тэрбум 266.8 сая.

Нийт дүнгээр 1 их наяд 931 тэрбум 782.2 сая.

Санал хураалт.

89 гишүүн буюу 80.9 хувиар санал дэмжигдлээ.

17 дугаар зүйл. 2025 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Архангай аймаг 14 тэрбум 505.7 сая.

Баян-Өлгий аймаг 14 тэрбум 26.3 сая.

Баянхонгор аймаг 23 тэрбум 502.4 сая.

Булган аймаг 15 тэрбум 258.1 сая.
Говь-Алтай аймаг 24 тэрбум 990.2 сая.
Дорноговь аймаг 55 тэрбум 686.9 сая.
Дорнод аймаг 30 тэрбум 428.3 сая.
Дорноговь аймаг 18 тэрбум 250.4 сая.
Завхан аймаг 17 тэрбум 294.9 сая.
Өвөрхангай аймаг 17 тэрбум 299.9 сая.
Өмнөговь аймаг 60 тэрбум 770.5 сая.
Сүхбаатар аймаг 26 тэрбум 562.7 сая.
Сэлэнгэ аймаг 31 тэрбум 299 сая.
Төв аймаг 28 тэрбум 947.2 сая.
Увс аймаг 16 тэрбум 422.8 сая.
Ховд аймаг 30 тэрбум 475.8 сая.
Хөвсгөл аймаг 20 тэрбум 848.6 сая.
Хэнтий аймаг 23 тэрбум 761.1 сая.
Дархан-Уул аймаг 21 тэрбум 288.8 сая.
Улаанбаатар хот 60 тэрбум 333 сая.
Орхон аймаг 38 тэрбум 727.7 сая.
Говьсүмбэр аймаг 8 тэрбум 374.3 сая.
Нийт дүнгээр 599 тэрбум 54.5 сая.
Дундговь аймаг 18 тэрбум 250.4 сая.

Дамдинням гишүүн давхар ярихгүй байхыг хүсье. Олон тоо уншиж байхад дундуур яриа орж ирээд болж өгөхгүй юм.

Санал хураалт.

84 гишүүн буюу 76.4 хувиар санал дэмжигдлээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2025 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Санал хураалт.

90 гишүүн буюу 81.8 хувиар санал дэмжигдлээ.

19 дүгээр зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт.

89 гишүүн буюу 80.9 хувиар санал дэмжигдлээ.

20 дугаар зүйл. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

21 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Санал хураалт.

90 гишүүн буюу 81.8 хувиар хууль эцэслэн батлагдлаа.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч дор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд 6 их наяд 927 тэрбум 203.2 сая, Ажил олгогчийн төлөх шимтгэл 2 их наяд 835 тэрбум 281 сая, Ажиллагчдаас төлөх шимтгэл 2 их наяд 285 тэрбум 157.4 сая, Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл 14 тэрбум 543.1 сая, Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл 146.6 сая, Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл 294 тэрбум 320 сая, Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл 6 тэрбум 158.8 сая, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл 2 тэрбум 353.8 сая, Бусад орлого 36 тэрбум 740.6 сая, Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1 их наяд 452 тэрбум 499.9 сая, **Нийт орлого** 6 их наяд 927 тэрбум 203.2 сая, Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл 294 тэрбум 322 сая.

Санал хураалт. Асуулт байхгүй. Дэгээрээ байхгүй. Санал хураалт.

91 гишүүн буюу 82.7 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

86 гишүүн буюу 78.2 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Нийт 95 гишүүн буюу 86.4 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээгээр орлогыг төвлөрүүлнэ:

Эрүүл мэндийн сайд 2 их наяд 514 тэрбум 881.8 сая, Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 1 их наяд 145 тэрбум 715.8 сая, Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 353

тэрбум 36.7 сая, Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 966 тэрбум 297.8 сая, Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 49 тэрбум 831.5 сая, **Нийт орлого 2 их наяд 514 тэрбум 881.8 сая.**

Санал хураалт.

91 гишүүн буюу 82.1 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал хураалт.

90 гишүүн буюу 81.8 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна.

Санал хураалт.

90 гишүүн буюу 81.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье. Мөн Баярмаа гишүүндээ баяр хүргэе. Өнөөдрийн санал дээр бүгд дээр нь дэмжиж санал өгч оролцож байна. Бас болдог юм байна санал өгвөл. Баярлалаа.

Дараагийн асуудалд оръё.

13.10 цаг

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батална.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн батлуулах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Санал хураалт.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

87 гишүүн буюу 79.1 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд оръё.

13.11 цаг

**“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хорооны, Жигжидсүрэнгийн Чинбүрэнг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

86 гишүүн буюу 78.2 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэх ажил байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Иргэн Батбаатарын Мөнгөнхишиг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн агаарын бохирдол, утааны асуудлаар нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нийтэлсэн.

Энэ өргөдөл 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 71350 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд хуваарилж байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөл, дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай бол холбогдох Байнгын хороодтой хамтран хэлэлцэх нь зүйтэй.

Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд асуудлыг шилжүүллээ.

13.13 цаг

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсьё.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд, энэ Тэмүүжин гишүүн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр санал хэлнэ.

Х.Тэмүүжин: Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбоотойгоор Улсын Их Хурал төсвийг алдагдалгүй болгох чиглэлээр ажиллалаа. Төсөв алдагдалгүй болохоосоо илүүтэйгээр бас үр ашигтай байх чиглэлээр дараа дараагийн төсөл дээр ажиллаасай гэж би хүсэж байгаа юм.

Гэхдээ энэ удаа эцсийн найруулгатай холбоотойгоор хэлэлцүүлэг дээр гарч байсан нэг зүйл дээр үнэхээр үг хэлэхгүй бол болохгүй нь. Ер нь Монгол Улс парламентын засаглалтай. Энэ засаглалынхаа хүрээнд ажиллаж чаддаг гэдгээ харуулахын тулд нэг зүйл хийхээс өөр арга алга. Өдөр бүхэн Засгийн газрын гишүүд парламентад худлаа хэлдэг болсон байна. Өчигдөр Жавхлан сайд яг өөдөөс харж байгаад л бас худлаа хэлсэн. Улсын Их Хуралд гишүүдэд тарааж өгсөн материал дотор Эдийн засгийн хөгжлийн сайд болон Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалт, их засвар гэдэг бичигтэй мөр байгаа байхгүй юу. Байсаар байхад ийм зүйл байхгүй ээ гээд л хэлж байгаа юм. Сайдууд Улсын Их Хуралд удаа дараа ингэж худлаа хэлж байна. Гэртээ, яаман дээрээ, гадуур худлаа хэлдгийг чинь хүмүүс толгойг нь нэлээд өнгөрөөдөг байж болно. Хууль тогтоох байгууллага дотор орж ирээд худлаа хэлж болохгүй. Парламентын засаглал бүхий улс орнуудад парламентыг үл хүндэтгэх гээд гэмт хэрэг байгаа. Парламент дуудахад төрийн албан хаагч ирэхгүй бол энийг гэмт хэрэг гэж үзэж байгаа юм. Дуудаад ирэхдээ парламентад тангараг өргөж байж үг хэлж байгаа. Би мэдэх ёстой хүрээндээ үнэнийг хэлнэ гэж байгаад. Энэ тангаргаа зөрчөөд худлаа хэлбэл гэмт хэрэг гэж үзэж байгаа. Одоо парламент ийм хүчтэй, хамтарсан Засгийн газар, их мөнгөтэй, нөөцтэй Засгийн газрыг хяная гэж бодвол үнэхээр парламентын чуулганд ирээд худлаа ярьдаг үйл ажиллагаа зогсох ёстой.

Монгол Улс худлаа ярьдаг, хууран мэхэлдэг өнгөө хууль тогтоох байгууллага дотор хүртэл ингэж өөгшүүлж болохгүй. Тийм учраас дараа дараагийн үйл ажиллагааг цэгцтэй хуулийн хүрээнд явуулахын тулд энэ парламентыг үл хүндэтгэх гэдэг энэ чиглэлээрээ гэмт хэрэг гэж бичдэг юм уу, хариуцлага тооцдог механизмаа бий болгохгүй алийн болгон ингэж хууртагдсан, худлаа ярьсан үгийнх нь араас сошиалаар хэрүүл хийж сууж байх вэ. Энийг л хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Зөв, маш чухал байр суурь хэлж байна. Энэ 126 гишүүнтэй болсон парламентын нэг том онцлог бол аливаа асуудлыг маш олон талаас нь харж чаддаг болчихсон. Дээрээс нь мэргэжлийн маш олон экспертүүд парламентын гишүүн болоод ороод ирчихсэн.

Тэгээд өмнөх ээлжит бус чуулган дээр ч хэлж байсан 10 дугаар сард төсөв хэлэлцэж байхын үед ч гэсэн миний зүгээс хэлж байсан төрийн албан хаагчид чуулганы хуралдаанд нэгдүгээрт хүндэтгэлтэй хандах ёстой.

Хоёрдугаарт, үнэн, зөв мэдээллийг бодитоор өгч байх ёстой. Үүнээсээ бол алдаа дутагдал гарвал хуулийн хариуцлага хүлээх хуулийн заалт нь байж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан:

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням.

Г.Дамдинням: Тэгэхээр бид нар 2025 оны төсвөө тэгээд л туйлширч хоёр тийшээ зүтгүүлсээр байгаад л тэгээд л ямар ч алдагдалгүй, өсөлт, хөгжил авчрахааргүй л ийм л юм руу явуулчихлаа. Тэгэхээр бид нар энэ тогтоолуудаар дамжуулаад Засгийн газарт нэгдүгээрт Хөрөнгө оруулалтын хуулиа яаралтай оруулж ир, төрийн өмчийн компаниудаа ашигт үйл ажиллагааг нь сайжруулах асуудлыг яаралтай шийд, гуравдугаарт, томоохон хөрөнгө оруулалтын гэрээнүүдээ, эдийн засгийг өөд нь татах энэ гэрээнүүдээ яаралтай оруулж ир гэдэг чиглэлийг өглөө.

Тэгэхээр Засгийн газар үндсэндээ бид нар Улсын Их Хурал тэгээд бүгдээрээ л энэ улс орныг хөгжүүлэхийн төлөө явж байгаа. Тэгээд бидний хувьд энэ улс орон нэг ч гэсэн бүтээн байгуулалт өрнөж, нэг ч гэсэн ажлын байр бий болж, нэг ч гэсэн татвар төлөгч нэмэгдэж байх чиглэлд л анхаарч ажиллах ёстой.

Тэгэхээр энэ тогтоолын төслийн хэрэгжилтийг бол бид нар хугацаагаар нь шахаад араас нь нэхээд явна шүү. Алдагдалгүй төсөв баталж өгсөн. Ажил хийх боломжгүй байна гэдэг гомдлыг та нараас сонсох боломжгүй шүү гэдгийг зориуд энэ тогтоол дээр бас хэлье.

Хоёрдугаар асуудал бол энэ Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилготой гэдэг нэрийн доор төрийн яамнууд, их, дээд сургуулиудыг нүүлгэх тухай асуудлуудыг яриад тэр асуудлууд нь шийдэгдэж дуусаагүй байхад газар, өмч хөрөнгийг нь зарах асуудлуудыг ярьж байна. Бид нар энийг хязгаарлах тогтоолын заалтыг энэ дагасан тогтоол дотор бол оруулж өгсөн. Бид нар сургууль, цэцэрлэгийн газруудаа зарж үрээд дуусгачихсан. Удирдах зөвлөл, ТУЗ гэдэг асуудлууд дээр дуусчихсан. Эмнэлгүүд дээрээ өргөтгөл барих газруудгүй болсон төрийн хөрөнгө оруулалтаар.

Хүүхдийн цэцэрлэг, сургуулийг барих газаргүй болсон. Одоо төрийн өмчид зөвхөн хэдэн яамны хэдэн газар л үлдчихсэн байгаа. Үүнийгээ бас Их Хуралд танилцуулж төлөвлөгөөгөө нарийн гаргаж ирж байж хий гэдэг чиглэлийг өгснийг бас энэ тогтоол батлагдаж байгаа явцад та бүгдэд бас хэлье. Газартай холбоотой асуудал бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхтэй холбоотой асуудал байдаг. Төрийн өмчтэй холбоотой асуудал ч гэсэн онцгой бүрэн эрхтэй холбоотой асуудал байгаа. Тэгээд энийг бас зориулж сануулж хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

11.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулга, Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Би өглөө үг хэлсэн. Тэгээд Энх-Амгалан сайдыг байхгүй байна гэсэн уг нь байсан юм байна лээ. 9.57-д ирцдээ орсон. Тэрнийг уучлаарай гэж хэлье.

Тэгэхээр Малчны тухай хуулийг Тэмүүлэн нарын 17 гишүүн өргөн барьж, 5 сард батлуулаад, энэ 24 оны 7 сарын 1-нээс хэрэгжих ёстой. Тэгээд энэ хуулиар малчдын НДШ-ийг нөхөн төлөх боломжийг нээж өгч байгаа юм. Маш их олон хүмүүс 2, 3 төлчхөөд тэтгэвэртээ гарчих ийм боломжийг л тэгээд ингээд заавал насаа хүргэх ийм л төлбөрөө төлж дуусгах тийм л юм боломж, юу руу аваачдаг юм л даа.

Тэгээд би бас хөдөөгүүр энэ сонгуульд оролцож явж байхдаа ийм сайхан хууль баталсан гээд зөндөө олон малчдад энийг тайлбарлаж хэлж явсан юм. Одоо болсон чинь ингээд өнөөдрийг хүртэл салбарын яам нь энэ хууль дагасан журмаа

өнөөдрийг хүртэл батлахгүй байгаад байгаа юм. Би үүнийг юу гэж харж байна вэ гэхээр яг тухайн үед малчдыг хуурсан юм байна саналаа авахын тулд. Би энэ хуулийг ингээд хэрэгжээд энэ чинь 7 сарын 1-нээс хэрэгжихэд нийтдээ 11 мянган хүн хамрагдах ёстой юм л даа. Тэгээд энэ хагас жил ингээд байхгүй болчихлоо.

Дээрээс нь дараагийн жил бүтэн жил хэрэгжих ёстой. Тэгээд энэ олон хүмүүс энийг хүлээгээд байгаад байдаг. Салбарын яам нь ерөөсөө энийгээ хэрэгжүүлдэггүй, журмаа гаргадаггүй. Энэнээс болоод олон хүмүүс хохирч байна. Тийм учраас Энх-Амгалан сайдыг энэ Малчны тухай хууль гарчхаад байна тэр хуулийг яаралтай хэрэгжүүлэх тэр ажлыг зохион байгуулаач ээ, тэр ажлаа хийгээч ээ, энэ дээр хариуцлагатай ажиллахыг танаас шаардаж байна. Журмаа батлуул.

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эцсийн найруулгатай холбоотойгоор Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд үг хэлнэ Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль.

Л.Энх-Амгалан: Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай хуульд оруулах тухай эцсийн найруулгыг бид нар сонсож байна л даа Пүрэвдорж гишүүнээ. Энэ ингээд эцсийн найруулга дээр төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас гэж тэтгэврийн сангийн алдагдал 1.4 их наяд хүрчихсэн байна. Одоо ингээд бид нар яг энэ баталж байна. 1.4 их наядын алдагдлыг, Тэтгэврийн сангийн алдагдлыг бид нар татвар төлөгчдийн мөнгөөр төлөх гэж байна. Татвар төлөгчдийн мөнгөөр. Энэ 1.4 их наяд яагаад үүнээс ингэж үүссэн юм бэ гэдэг яг сая таны хэлж байгаа цөөхөн хэдэн хуулийн хэрэгжилтээс болж өнөөдөр зөвхөн 25 оны улсын төсөв дээр бид нар 1.4 их наяд, 26 оны улсын төсөв дээр бид нар 1.8 их наяд, 27 оны улсын төсөв дээр бид нар 3.8 их наядын алдагдлыг татвар төлөгчдийн мөнгөөр бид нар төлөх гэж байна.

Дахиад дээрээс нь өнгөрсөн хугацаанд малчдын тэтгэврийн насыг 5 насаар наашлуулсан хууль, 10 жилийг нөхөн тооцсон энэ хуулиуд дээр бид нар тэтгэврийн сан дээр 4.7 их наядын бид нар ачааллыг өгсөн байна Пүрэвдорж гишүүн ээ. Өгсөн байна тийм ээ. Одоо би аль аль сайдын үед ийм хууль баталсныг хэлж болно. Гэхдээ танай, манай гээд яах вэ энэ тэтгэврийн сан бол Монгол Улсын тэтгэврийн сан. Монгол Улсын ирээдүй Тэтгэврийн сантай байх ёстой гэж би ойлгож байгаа.

Тийм учраас одоо цөмөөрөө хийсэн алдаануудаасаа ард түмнээсээ уучлалт гуйя. Одоо энэ Тэтгэврийн сан дээр дахиж ачаалал өгөх, тэтгэврийн санг дахиж алдагдалд оруулах бид нар ч нэг хуулийн төсөл, нэг ч журам бид нар баталж болохгүй л гэж ойлгож байгаа. Ингэж 126 гишүүн өнөөдөр Монголын ард түмний төлөөлөл болж сууж байгаа. Ингэж бид нар эвслийн Засгийн газар гэж тэтгэврийн шинэчлэлийг хийхийн тулд бид нар эвслийн Засгийн газрыг байгуулсан.

Тийм учраас одоо бид нар ард түмэндээ таалагдах гэж оролдсон ийм ийм явуургүй ойрын зайн улс төрөө больё.

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ талархал дэвшүүлье. Та бид ээлжит хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны төсвийг хоёр дахь удаагаа хэлэлцэн баталлаа. Шинэ парламентын эхний ээлжит чуулганы томоохон сорилт болсон энэ удаагийн төсвийн хэлэлцүүлэг онцлогтой, бас олон талын сургамжтай байлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд 2025 оны улсын төсөв болон түүнтэй холбоотой гарсан Улсын Их Хурлын өмнөх шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан. Улсын Их Хурал энэ хоригийг хэлэлцээд бодлого эрх зүйн бүрэн үндэслэлтэй хэмээн үзэж хүлээн авсан. Энэ үндсэн дээр Улсын Их Хурлаас Засгийн газарт алдагдалгүй төсвийн төсөл боловсруулах чиглэл өгсөн, шийдвэр гарсан зэрэг нь нийгмийн анхаарал татсанаараа онцлогтой байсан. Энэ бол парламентын сул тал, чадамжгүй тухай асуудал биш. Харин төрийн эрх мэдлийн харилцан хяналт, тэнцвэрт байдлыг хангаж, хууль дээдлэх үндсэн зарчмаа хэрэгжүүлж, иргэн ба улсын эрх ашигтай холбогдсон чухал асуудлыг ард түмний хэлэлцүүлэгт дахин оруулсан нь парламентад ёсны эерэг хандлага гэж үзвэл зохино.

Монгол Улсын Ерөнхийлөгч болон парламентаас чиглэл болгосны дагуу Монгол Улсын Засгийн газар бүхэлд нь дахин боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 4-нд ирүүлснийг Улсын Их Хурал цаг алдахгүй зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч олон талын оролцоотой бүтээлч хэлэлцүүлгийг хуулийн дагуу 4 үе шаттай хэлэлцлээ. Улсын Их Хурлын гишүүд олон ургалч үзлээр асуудалд хандлаа.

Ийнхүү улсын төсөвт цаг алдахгүй хэлэлцэж баталснаар ард иргэдийн ажил, амьдрал, бизнес эрхлэгч аж ахуйн нэгж төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүй хэвийн үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлж чадлаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдаж буйтай холбогдуулан дараа дараачийн холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод асуудлаа нягт хэлэлцэж Улсын Их Хурлын гишүүд ойлголтоо нэгтгэх, төсөв хэлэлцэх онцлог, үүнтэй холбоотой дэгээ мөрдөж ажилладаг байх. Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлогын бодитой суурийг тавих, төсвийг дахин хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, бүтэц, чиг үүргийн уялдаа холбоонд анхаарах, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, төрийн байгууллагууд орон нутгийн 2025 оны холбогдох төсвөө яаралтай батлах, Төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлагдах хүртэлх энэ шат дарааллын цаглаврыг жигдрүүлж холбогдох хууль, тогтоомжийг иж бүрэн ойлгомжтой болгох хэрэгтэй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг мөрдөж, Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар улсын төсөв батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд асуудлыг олон ургалч үзэл, бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэх зарчим баримтлан 2025 оны төсвийн хэлэлцүүлгийг хэлэлцэн ийнхүү баталж чадлаа.

Та бүхэндээ баярлалаа. Мөн ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

13.28 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

